



Сүхбаатар аймгийн ЗДТГ, БОАЖГ

СҮХБААТАР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

(2021-2026 ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР)



АГУУЛГА

Нэг. Монголын болон зүүн бүсийн аялал жуулчлалын статистик	2
1.1 Монголын аялал жуулчлалын нөөц	
1.2 Хэнтий аймгийн аялал жуулчлалын нөөц	
1.3 Дорнод аймгийн аялал жуулчлалын нөөц	
Хоёр. Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал	7
2.1 Сүхбаатар аймгийн сумдын аялал жуулчлалын өрсөлдөх чадвар	
2.2 Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын нөөц	
2.3 Жуулчдын статистик	
2.4 Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын зах зээл дэх өнөөгийн нөхцөл байдлын swot шинжилгээ	
2.5 Сүхбаатар аймгийн сумдын аялал жуулчлалын нөөц боломж	
Гурав. Аялал жуулчлалын шилдэг газрыг хөгжүүлэх менежмент	25
3.1 Дарьганга – аялал жуулчлалын цогцолбор бүс байгуулах менежмент	
3.2 Эрдэнэцагаан сумыг аялал жуулчлалын дэд бүс болгон хөгжүүлэх менежмент	
3.3 Аяллын маршрутыг баяжуулах боломжтой бусад зорих газрууд	
Дөрөв. Сүхбаатар аймагт хөгжүүлэх боломжтой аяллын төрөл	51
4.1 Шувуу ажиглах аялал	
4.2 Нүүдэлчдийн соёлтой танилцах аялал	
4.3 Морин аялал	
4.4 Соёлын аялал жуулчлал	
Тав. Аялал жуулчлалын маркетинг, менежмент	61
5.1 Аялал жуулчлалын газар олголт	
5.2 Аялал жуулчлалын сурталчилгаа	
5.3 Жуулчны мэдээллийн төв	
5.4 Аялал жуулчлалын үзэсгэлэн	
5.5 Зочид буудлын зохион байгуулалтын схем	
5.6 Рестораны зохион байгуулалтын схем	
5.7 Нутгийн брэнд бүтээгдэхүүн хөгжүүлэлт	
5.8 Авто зам дагуух түр зогсоол	
5.9 Эко бие засах газар буюу хуурай жорлон байгуулах стандарт	
Зургаа. Сүхбаатар аймгийн аяллын үндсэн маршрут	79
Маршрут 1: УБ – Баруун-Урт – Алтан овоо – Шилийн богд – Баруун-Урт – УБ (1546км)	
Маршрут 2: УБ – Сайншанд – Хамарын хийд – Хужирт – Онгон таван булаг – Дарьганга – УБ (1710км)	
Маршрут 3: УБ – Түвшинширээ – Баяндэлгэр – Дарьганга – Баруун-Урт – УБ (1608км)	
Маршрут 4: УБ – Баяндэлгэр – Онгон – Дарьганга – Эрдэнэцагаан – Сүхбаатар – Баруун-Урт (2000км)	
Маршрут 5: УБ – Чойбалсан – Матад хан – Шилийн богд – Алтан овоо – Чойбалсан (986км)	
Маршрут 6: УБ – Хэнтий аймаг – Дорнод аймаг – Сүхбаатар аймаг – УБ (2840км)	

ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Засгийн газрын 2015.05.29-ний өдрийн 324 тоот тогтоолоор “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. 2016 онд “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-д аялал жуулчлалын дэд бүтцийн чанарыг сайжруулах, эко аялал жуулчлалын бүсүүдийг батлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хөгжүүлэх, аялагч жуулчдын тоог 1 саяд хүргэх зорилтуудыг дэвшүүлсэн. Засгийн газрын 2018.06.13-ны өдрийн 171 тоот тогтоолоор “Аялал жуулчлалын гол чиглэл”-ийг баталсан бөгөөд Сүхбаатар, Хэнтий, Дорнод аймагт ТҮҮХЭН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРШРУТ хөгжүүлэхийг онцлон тусгасан.

2013 онд Сүхбаатар аймгийн ИТХ-аас “АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ”-г баталж Сүхбаатар аймагт түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалаас иргэдийн олох ашиг орлогыг нэмэгдүүлэх, Шилийн богдын аялын маршрутыг гол бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхээр төлөвлөсөн.

“СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ 2020 – 2028” бодлогод тус аймгийн хөгжлийн тэргүүлэх чиглэлийн хоёрдугаарт “Шинжлэх ухаан, технологи, инноваци, дэд бүтцэд тулгуурлан өрсөлдөх чадвар бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлэх замаар бие даасан эдийн засгийн хөгжлийг хангана” гэж заасан. Мөн “Сүхбаатар аймгийн Засаг даргын 2020 – 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэхээр тусгасан.


Эдгээр зорилго, зорилттой уялдуулан “Сүхбаатар аймгийн хөгжлийн хэтийн зорилт”-ын 5.3.1-д “Аймгийн аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ хийж зөвлөх үйлчилгээ авч, урт хугацааны хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх” хэмээх заалтыг үндэслэн энэхүү судалгаа төлөвлөлтийг ажлыг хийсэн болно.

Баримталсан арга зүй: Тус төлөвлөгөөг боловсруулах ажлыг “судалгаа, дүгнэлт, дэвшүүлэх санаа, төлөвлөлт” гэсэн арга зарчмаар боловсруулсан бөгөөд УИХ, ЗГ, Сүхбаатар аймгийн бодлого чиглэлүүдэд тусгасан аялал жуулчлалын зорилго зорилтыг хэрэгжүүлэх боломж, нөөц даац, Сүхбаатар аймгийн 13 сумаас 8 сумын нутагт хийсэн хээрийн судалгааны тайлан тэмдэглэлд тулгуурлан “Аялал жуулчлалын гол бүсийн хөгжлийг тодорхойлж, үндсэн болон дэд маршрутыг нарийвчлан тогтоож, түүний дагуу менежментийн төлөвлөлтийг бий болгох зорилгоор тус баримт бичгийг боловсрууллаа.


Зохион байгуулсан судалгааны үр дүн, дэвшүүлсэн санаа, төлөвлөсөн үйл ажиллагаа, өгч буй зөвлөмжүүд нь цаашид тус аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх үндсэн бодлого болж, улмаар хэрэгжилтийн дэд хөтөлбөр, төслүүдэд тодорхой тусгагдах чиглэл болно гэж үзэж байна.

НЭГ. МОНГОЛЫН БОЛОН ЗҮҮН БҮСИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СТАТИСТИК


1.1 МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ



1.2 ХЭНТИЙ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ (2018 он)



1.3 ДОРНОД АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ (2019 он)



ХОЁР. СҮХБААТАР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Сүхбаатар аймаг нь аялал жуулчлалаа хөгжүүлэх зорилгоор нөөц даацын судалгаа төлөвлөлтийг 2013 онд зохион байгуулж “Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөө” боловсруулсан. Сүхбаатар аймгийн 8 гайхамшигаар “Алтан овоо, Шилийн богд, XII-XIII зууны хүн чулуун хөрөг, Чингисийн Алтаг урагийн олдвор, Дарьгангын мөнгөн үрлал, Талын агуй, Хунгийн чуулган, Хялганат тал хээр, Хурдан шандаст хүлгүүд”-ийг тодруулсан. Бичигтийн боомтыг түшиглэн хил дамнасан болон хил орчмын аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэхээр төлөвлөсөн хэдий ч БНХАУ-ын иргэд хил гаалиар зорчих эрхзүйн асуудал өнөөдрийг хүртэл шийдэгдээгүй байна.

Дотоод гадаадын жуулчдад зориулан “Хийморийн аялал”, “Хутагтуудын нутгаар”, “Оны анхны нар харах аялал”, “Хил орчмын аялал”, “Хунгийн чуулган үзэх” аялал, монгол уламжлал, зан заншил, тэр дундаа дарьганга, үзэмчин соёлтой танилцах соёлын аяллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсээр ирсэн байна.

Дарьганга суманд Шилийн богд тэргүүтэй 220 гаруй унтарсан галт уул, 127-248 км.кв талбай эзлэх Онгон ба Молцог элс, Лхачинвандад уул, Баяндулаан, Талын агуй, Баяндулаан уулын агуй, Лог, Будар, Зараа, Төрөнгө, Дэлгэрхаан, Харгилтай зэрэг үлэмж талбай бүхий чулуун тогтоцтой уулс хөндий, амьтан ургамлын чулуужсан ясны үлдэгдэлтэй Байшинт, Ходоодын говь, Хорголжингийн тал зэрэг байгалийн дурсгалт газруудтай.

“Сүхбаатар аймгийн хөтөч” ном, “Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын газрын зураг”-ийг 2016 онд аймгийн БОАЖГ-ын мэргэжилтэн П.Ариунболд эмхэтгэн гаргасан. Ганга нуурын “Хунгийн чуулган”-аар сэдэвлэсэн эвент нь алдартай бөгөөд тогтмолжих хандлагатай болсон. 2019 оноос “Агтана хүрээт” өвлийн наадмыг зохион байгуулдаг болсноор дотоодын аялагчдын сонирхлыг татаж эхлээд байна.


Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын стратегийн ач холбогдолтой газрууд нь Алтан-Овоо, Ганга нуур, Шилийн богд, Талын агуй юм. Баруун-Урт хот аялагч жуулчдын дайран өнгөрөх эхний цэг, Дарьганга сум нь гол зорин очих газар бөгөөд хоол үнд болон байршуулах үйлчилгээ, бэлэг дурсгалын үйлдвэрлэл, музей үзвэр, соёл урлагийн үйлчилгээгээр татаж эдийн засгийн эргэлтийг хэд дахин нэмэгдүүлэх боломжтой. Түвшинширээ, Баяндэлгэр, Онгон сумуудад шинээр аялал жуулчлалын бүтээгдэхүүн, маршрутууд төлөвлөж, тансаг зэрэглэлийн жуулчны бааз байгуулах хэрэгтэй нөхцөл харагдаж байна. Хил орчмын аялал жуулчлал, Дорнод ба Сүхбаатар аймгийг холбосон аялал жуулчлалаар Эрдэнэцагаан сум эргэлтэнд орох ба маршрутын замд жуулчны бааз байгуулах шаардлагатай болно.

2.1 СҮХБААТАР АЙМГИЙН СУМДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨРСӨЛДӨХ ЧАДВАР


№	Сумын нэрс	Байгаль нөөц	Түүхийн нөөц	Музей	Зочид буудал	Жуулчны бааз	Дэн буудал	Хоолны газар	Эвент	Тахилгат уул	Буддын сүм хийд	Христ, Исламын сүм	Банк	АТМ	Утасны мөljээ	ШТС	Газын станц	Цэцэрлэгт талбай	Нийт тоо	Байр
1	Асгат	12	2	=	=	=	1	=	=	1	=	=	2	=	4	1	=	=	23	
2	Баруун-Урт	=	=	1	8	3	1	6	1	=	1	=	4	4	4	6	2	2	43	III
3	Баяндэлгэр	15	4	=	1	=	2	4	=	1	2	=	2	2	4	3	=	=	40	
4	Дарьганга	18	9	1	=	3	3	4	1	2	1	=	2	=	4	2	=	1	51	II
5	Мөнххаан	10	2	1	=	=	2	5	1	1	1	=	2	1	4	2	=	1	33	
6	Наран	7	4	=	=	=	2	1	1	1	1	=	2	=	4	1	=	2	26	
7	Онгон	3	6	=	=	=	3	4	=	2	1	=	2	2	4	3	=	=	30	
8	Сүхбаатар	16	2	1	=	=	3	6	1	1	1	=	2	2	4	2	=	1	42	
9	Түвшинширээ	27	4	=	=	=	2	4	1	2	2	=	2	=	3	3	=	1	51	II
10	Түмэнцогт	5	=	1	1	=	2	4	1	1	1	1	2	=	4	2	1	1	27	
11	Уулбаян	9	=	=	=	=	=	2	1	3	1	=	2	=	4	1	=	1	24	
12	Халзан	6	=	=	=	=	1	2	=	1	1	=	2	=	4	1	=	=	18	
13	Эрдэнэцагаан	11	10	1	5	1	1	7	=	4	1	=	2	2	4	2	=	1	52	I
		139	43	6	15	7	23	47	8	20	14	1	28	13	51	29	3	11		

Сүхбаатар аймгийн БОАЖГ, Монголиан гайд түр ХХК хамтран хэрэгжүүлсэн хээрийн судалгааны үр дүнгээс үзэхэд Сүхбаатар аймгийн сумдын байгалийн болон түүх соёлын нөөц, дэд бүтэц, соёлын эвент ба музей үзвэрийн газар, зоогийн газар, зочид буудал, жуулчны бааз зэргийг дүгнэж үзэхэд Эрдэнэцагаан, Дарьганга сум, Түвшинширээ сумууд тэргүүлсэн байна. Байгалийн үзэсгэлэнт байдал, түүхэн ач холбогдлоороо Баяндэлгэр сум маршрутын эргэлтэнд орох боломжтой харагдаж байна. Мөн жуулчдын үрсгалаас ихээхэн хэмжээний ашиг хүртэж эдийн засгийн багагүй эргэлт хийж хөгжих боломжтой сум бол Баруун-Урт сум юм хэмээн дүгнэлээ.

2.2 СҮХБААТАР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ



2.3 ЖУУЛЧДЫН СТАТИСТИК



2.4 СҮХБААТАР АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН SWOT ШИНЖИЛГЭЭ

S

- Түүх соёлын өв болох чулуун дурсгал, тэр дундаа дундад зууны үед хамаарах “хүн хөрөг”-ийн дурсгалаар тэргүүлдэг.
- Дарьганга өв соёл хэмээх бие даасан өв уламжлалтай.
- Аялагчдын хөлд дарагдаж талхлагдаагүй, зам харьцангуй сайн
- Хурдан морьдын удам, адуу эдлэх соёл бий.
- Байгаль орчин харьцангуй онгон дагшин хэвээр байгаа.
- Байнгын ажиллагаатай хилийн 1 боомттой.
- Төрийн тахилгат “Алтан овоо” уул, шүтлэг бишрэлийн Шилийн богд уул алдартай.
- 2013 онд аймгийн аялал жуулчлалын нөөц боломжийн суурь судалгаа хийгдсэн.
- Бичигтийн боомтод тулгуурласан “Хил орчмын аялал жуулчлалын хөгжил”-д туршлагатай.



ДАВУУ ТАЛ

W

- Төр, ТББ, Хувийн хэвшлийн хамтын ажиллагааны суурь тавигдаагүй.
- 2013 онд төлөвлөсөн “Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө”-ний хэрэгжилт сул.
- Аймгийн аялал жуулчлалын маршрутын ганцхан үрсгалтай.
- Сумуудад дэн буудал, гэр буудал хөгжөөгүй, замд түр буудаллах цэг байхгүй.
- Шилийн богд, Ганга нуурын аялал нь нэг л замаар эргэлддэг.
- Уул уурхайн ордуудаас орон нутгийн хөгжилд оруулсан дорвитой хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт байхгүй.
- Малын даац хэтэрсэн, бэлчээрийн хомсдол үүссэн.



СУЛ ТАЛ

O

- Аймгийн ИТХ-д “аялал жуулчлалыг дэмжих” лобби бүлэг байгуулах
- Орон нутгийн аялал жуулчлалын түр оператор байгуулах
- Аймгийн аялал жуулчлалын холбоог байгуулах
- Сүхбаатар коллежид аялал жуулчлалын хүний нөөц бэлдэх
- Аялал жуулчлалын маршрутыг нэмэгдүүлэх, шинэ эвентийг хөгжүүлэх
- Аялал жуулчлалын тандалт судалгааны аргачлал боловсруулах



БОЛОМЖ

T


- Аялал жуулчлалын нөөц газруудад дэд бүтэц хөгжүүлэхэд ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай.
- Байгалийн гамшиг буюу тал хээрийн түймэр үүсэх эрсдэл өндөр.
- Ганга нуурын усны түвшин доошлох, ширгэх эрсдэлд ойрхон, нүүдлийн шувуудын амьдрах орчин алдагдах, дайжих
- Дарьганга, үзэмчин ёс заншил, амьдралын хэв маяг хэт орчин үежих, үндэсний хувцасны соёл багасах, мартагдах
- Гадны хөрөнгө оруулагчдад дургүйцэх, нутгархах, өмчирхөх үзэл аялал жуулчлалын хөгжилд саад учруулах




ЭРСДЭЛ

2.5 СҮХБААТАР АЙМГИЙН СУМДЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН НӨӨЦ БОЛОМЖ

АСГАТ СУМ



	УБ ХОТООС 601км Аймгийн төвөөс 45км		НУТАГ ДЭВСГЭР 720800ГА		ХҮН АМ 1948		МАЛЫН ТОО 184920
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 1 = 5 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР =		БАНК, АТМ 2 = 0		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 1
	МУЗЕЙ =		БУДДЫН СУМ =		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 1		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ =
	УЛСЫН ТХГН =		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН =		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 1		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛАГА =




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Авдарын уул
- Баян уул
- Асгат уул
- Өвөр хүрэм
- Мухар
- Сэнжит
- Авдарын гол
- Цагаан булаг
- Хавирга гол
- Авдарын хийдийн туурь
- Хойд урд таван чулуу
- Хэнгэрэг хад
- Цагаан суварганы хүн чулуу
- Зэл чулуу

Асгат суманд Сүхбаатар аймгийн төв цэг оршдог.

БАРУУН-УРТ СУМ




	УБ ХОТООС 556км		НУТАГ ДЭВСГЭР 5400га		ХҮН АМ 22548		МАЛЫН ТОО 435010
	ЗОЧИД БУУДАЛ 8 = 156 ортой		ЖУУЛЧНЫ БААЗ 3 = 132 ортой		ДЭН БУУДАЛ 1 = 6 ортой		СУВИЛАЛ 1 = 40 ортой
	ЦАЙНЫ ГАЗАР 6		БАНК, АТМ 4 = 4		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 6 + ГАЗ 2
	МУЗЕЙ 1		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ =		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ-1 НАР ХАРАХ АЯЛАЛ
	УЛСЫН ТХГН =		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 2		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 20		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА =


ОНЦЛОХ МЭДЭЭЛЭЛ:

- Сайншандаас 350 км
- Чингисхаан хотоос 230 км
- Чойбалсан хотоос 190 км зайд байрладаг.
- Баруун-Урт хэмээх жижиг голын хөвөөн дээр байрладаг.
- Засаг захиргааны 4 хороо, 9 багтай.
- 1994 онд "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль"-ийн дагуу хотын статустай аймгийн төв болсон.
- Аймгийн ЗДТГ-ын дэргэд "Хотын захирагчийн алба" байгуулагдсан.
- Хотын дэд бүтэц, хот төлөвлөлтийн төлөвлөгөөтэй.

БАЯНДЭЛГЭР СУМ




	УБ ХОТООС 600км Аймгийн төвөөс 150км		НУТАГ ДЭВСГЭР 75450га		ХҮН АМ 5089		МАЛЫН ТОО 503470
	ЗОЧИД БУУДАЛ 1 = 10 ортой		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 2 = 20 ортой		СУВИЛАЛ 1 = 12 ортой
	ЦАЙНЫ ГАЗАР 4		БАНК, АТМ 2 = 2		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 3
	МУЗЕЙ =		БУДДЫН СУМ 2		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 1		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ =
	УЛСЫН ТХГН 1		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН =		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 3		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА 2 ЗАСТАВ




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Орлой гурван зээрд
- Ongon tavan bulag
- Өөш морин хошуу
- Өргөө таван толгой
- Өргөн цагаан дэрс
- Тойг тээгийн тал
- Төгрөг гүйлстэйн нуруу
- Дөхөмийн говь, Дөхөмийн баян овоо
- Ongon элс
- Хужиртын ам
- Дунд булгийн цоорхой, Цагаан булаг
- Хужиртын хавцал, хадны бичээс
- Замын нуурын хадны бичээс
- Бударгана
- Байшинтын туурь

ДАРЬАНГА СУМ




	УБ ХОТООС 780км Аймгийн төвөөс 180км		НУТАГ ДЭВСГЭР 481100га		ХҮН АМ 3137		МАЛЫН ТОО 224920
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ 3 = 176 ортой		ДЭН БУУДАЛ 3 = 24 ортой		СУВИЛАЛ 1 = 20 ортой
	ЦАЙНЫ ГАЗАР 2		БАНК, АТМ 2 = 0		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 2
	МУЗЕЙ 1		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 2		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ-2 АГТАНА ХҮРЭЭТ ГАНГЫН ЧУУЛГАН
	УЛСЫН ТХГН 1		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 1		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 4		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА 2 ЗАСТАВ




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Д.т.д 1100-1778м өндөр өргөгдсөн эртний сөнөсөн 200 гаруй галт уултай.
- Шилийн богд уул
 - Төрийн тахилгат Алтан-Овоо
 - Дашдангаа уул
 - Ганга, Хөдөө, Дуут, Холбоо, Уянгын цагаан нуурууд
 - Дагшин булаг, Оргихын булаг, Баянбулаг
 - Молцог элс
 - Талын агуй, Торой бандийн хөшөө
 - Сэнжит хад, Агтан хүрээт
 - Бичигтийн шахаа
 - Ламтын хүн чулуу, Хөргийн хөндийн хүн чулуу
 - Хаан, хатан, бэр, хүү хөрөг, Хонгорын хүн чулуу
 - Гөхөлийн ширээний хүн чулуу, Хүнт ухаагийн хүн чулуу
 - Сүмтийн туурь
 - Эрээнтолгойн рашаан, Рашаант

МӨНХХААН СУМ




	УБ ХОТООС 460км Аймгийн төвөөс 103км		НУТАГ ДЭВСГЭР 740700га		ХҮН АМ 4913		МАЛЫН ТОО 441350
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 2 = 6 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 5		БАНК, АТМ 2 = 1		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 2
	МУЗЕЙ 1		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 1		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ-1 УГСААТНЫ СОЁЛЫН ҮЗЭСГЭЛЭН
	УЛСЫН ТХГН =		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 1		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 5		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА =




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРУУД:

- Д.т.д 1100-1600м өргөгдсөн уулстай.
- Мөнххаан уул
 - Заанширээ уул
 - Улаанхад
 - Дэлгэрчандмань уул
 - Баянтэрэм
 - Цагаан ус
 - Шинэ ус
 - Цээл
 - Хоолойн худаг зэрэг тал хөндий
 - Устай бургастай
 - Ачаат уяат уулын булш хиргисүүр

НАРАН СУМ




	УБ ХОТООС 776км Аймгийн төвөөс 220км		НУТАГ ДЭВСГЭР 330200га		ХҮН АМ 1670		МАЛЫН ТОО 124530
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 2 = 12 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 1		БАНК, АТМ 2 = 0		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 1
	МУЗЕЙ =		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 1		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ 1
	УЛСЫН ТХГН 1		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 2		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ =		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА 2 ЗАСТАВ




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРУУД:

- Д.т.д 1172-1560м өндөрт өргөгдсөн ухаа гүвээт тал зонхилсон нутаг.
- Хамгийн өндөр цэг нь Баяндулаан уул 1749
 - Молцог элс
 - Логийн чулуу
 - Ачаа чулуу
 - Гэр чулуу
 - Баяндулааны агуй
 - Бэрхийн гүү
 - Мандалын хүн чулуу
 - Ноён хөндийн хүн чулуу
 - Сөдөтийн цагаан чулууны бичээс
 - Ганзайн хадны адууны зураг

ОНГОН СУМ




	УБ ХОТООС 720км Аймгийн төвөөс 170км		НУТАГ ДЭВСГЭР 699700га		ХҮН АМ 3870		МАЛЫН ТОО 342130
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 3 = 16 ортой		СУВИЛАЛ 1 = 10 ортой
	ЦАЙНЫ ГАЗАР 4		БАНК, АТМ 2 = 2		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 3
	МУЗЕЙ =		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 2		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ =
	УЛСЫН ТХГН 1		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН =		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 1		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА 1 АНГИ + 2 ЗАСТАВ




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Бударын хад
- Шартын хад
- Адуун чулуу
- Хөрөгтийн хүн чулуу
- Шивээтийн хүн чулуу
- Шартын хадны хүн чулуу
- Таван толгойн хүн чулуу
- Онгон элсний Хүннүгийн булш
- Таван толгойн XIII зууны язгууртны дурсгал

СҮХБААТАР СУМ




	УБ ХОТООС 610км Аймгийн төвөөс 54км		НУТАГ ДЭВСГЭР 1276400га		ХҮН АМ 3505		МАЛЫН ТОО 381470
	ЗОЧИД БУУДАЛ 1 = 10 ортой		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 2 = 10 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 6		БАНК, АТМ 2 = 2		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 2
	МУЗЕЙ 1		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 1		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ-1 НАР ХАРАХ АЯЛАЛ
	УЛСЫН ТХГН 2		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 1		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 4		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА =




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Дорнод аймгаас 170 км.
- Анагаах увидастай Талбулаг
 - Дүнгэнэдгийн рашаан
 - Хайлст ханан
 - Хаахлайн цэвэр цэнгэг ус
 - Зүүн, Баруун баян гол
 - Гүнбулаг, Яргайт, Наранбулаг, Тугал булаг
 - Тахилгат Баянмөнх хаан буюу Дарханхаан
 - Хундар
 - Баян-Эрхэт
 - Баянцагаан
 - Эрдэнэ-Овоо
 - Хайлааст
 - Нийгмийн хонгор – цогцолбор

ТҮВШИНШИРЭЭ СУМ




	УБ ХОТООС 478км Аймгийн төвөөс 136км		НУТАГ ДЭВСГЭР 439100га		ХҮН АМ 3426		МАЛЫН ТОО 314710
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 2 = 10 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 4		БАНК, АТМ 2 = 0		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 3
	МУЗЕЙ =		БУДДЫН СУМ 2		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 2		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ-1 ГУРВАН ҮЕИЙН ЧУУЛГА УУЛЗАЛТ
	УЛСЫН ТХГН =		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 1		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ =		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА =




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Өндөрхаанаас 175 км, Сайншандаас 210 км зайтай.
- Ширээт, Өлзийт, Халх хошуу, Малгар, Дэлгэрхаан, Үнэгт, Орцог, Зараа, Суман, Цант, Төрөнгийн хад, Арингийн чулуу
 - Их бага булаг, Алтанбулаг, Хулгар, Хавцал, Адгийн булаг
 - Замт, Өргөө тойром, Сангийн далай, Хөвөнт, Шүүт нуур
 - Билгэх, Тоглох
 - Өгөөмөрийн говь
 - Цагаан элэгний хадны сүг зураг
 - Хадан усны агуйн зураг
 - Зэл чулуу
 - Сэнжит хад
 - Алтан булгийн хийд
 - Донгойн ширээ - Түрэгийн цогцолбор дурсгал

ТҮМЭНЦОГТ СУМ




	УБ ХОТООС 480км Аймгийн төвөөс 160км		НУТАГ ДЭВСГЭР 213000га		ХҮН АМ 2499		МАЛЫН ТОО 135630
	ЗОЧИД БУУДАЛ 1 = 16 ортой		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 2 = 20 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 4		БАНК, АТМ 2 = 0		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 2 + ГАЗ 1
	МУЗЕЙ 1		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 1		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ 1
	УЛСЫН ТХГН 1		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 1		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 7		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛАГА =




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Инээдэг хад
- Арслан хад
- Жамбалнавгийн агуй
- Түмэнцогт уул
- Хар Ямаатын уул

УУЛБАЯН СУМ




	УБ ХОТООС 480км Аймгийн төвөөс 79км		НУТАГ ДЭВСГЭР 493800га		ХҮН АМ 2977		МАЛЫН ТОО 241810
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ =		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 2		БАНК, АТМ 2 = 0		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 1
	МУЗЕЙ =		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 3		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ-1 ШАШНЫ ЭВЕНТ
	УЛСЫН ТХГН =		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 1		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 2		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА =




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРУУД:

- Гурван цагаан булангийн нуруу
 - Гуч-Сурваа
 - Дов ухаа
 - Хагтад-Овоо
 - Буман салаа
 - Булан хоймор
 - Ходоодын говь
 - Ар өлзийт
 - Дэлгэр
- Жоншны орд газарт Хятадын хөрөнгө оруулалттай 2 компани олборлолт явуулдаг.

ХАЛЗАН СУМ




	УБ ХОТООС 478км Аймгийн төвөөс 136км		НУТАГ ДЭВСГЭР 379700га		ХҮН АМ 1832		МАЛЫН ТОО 164780
	ЗОЧИД БУУДАЛ =		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 1 = 5 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 2		БАНК, АТМ 2 = 0		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 1
	МУЗЕЙ =		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 1		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ =
	УЛСЫН ТХГН =		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН =		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 2		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА =




БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ГАЗРУУД:

- 1224 метр өндөр Шарга уул
- 1100 метр Цагаан овоо
- Дэмбэрэл
- Шовдол
- Баян-Уул
- Хатавчийн хавцал

ЭРДЭНЭЦАГААН СУМ



	УБ ХОТООС 777км Аймгийн төвөөс 217км		НУТАГ ДЭВСГЭР 1697300га		ХҮН АМ 6893		МАЛЫН ТОО 398890
	ЗОЧИД БУУДАЛ 6 = 105+80 ортой		ЖУУЛЧНЫ БААЗ =		ДЭН БУУДАЛ 1 = 8 ортой		СУВИЛАЛ =
	ЦАЙНЫ ГАЗАР 7		БАНК, АТМ 2 = 2		УТАСНЫ СҮЛЖЭЭ 		ШТС 2
	МУЗЕЙ 1		БУДДЫН СУМ 1		СУМЫН ТАХИЛГАТ УУЛ 4		ЭВЕНТ АРГА ХЭМЖЭЭ =
	УЛСЫН ТХГН 3		ЦЭЦЭРЛЭГТ ХҮРЭЭЛЭН 1		ЦЭВЭР УСНЫ ХУДАГ 4		ХИЛИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГА 1 АНГИ + 10 ЗАСТАВ



БАЙГАЛЬ, ТҮҮХ, СОЁЛЫН ДҮРСГАЛТ ГАЗРУУД:

- Дархан цаазат Лхачинвандад уул
 - Зотол хаан, Уртын цагаан овоо
 - Норов уул, Бяруутын баян цагаан, Чандмань уул
 - Хөндлөн Хайлааст
 - Хэцүүгийн ам, Яам хад
 - Баян хайлс, Мойлтын өндөр
 - Дугнагарын хүн чулуу
 - Жаргалантын ширээний хүн чулуу, сүг зураг
 - Зэгстэйн хүн чулуу, Сэрхийн далангийн хүн чулуу
 - Нүхт, Хаалгатын хүн чулуу, Хонгорын голын хүн чулуу
 - Егүзэр хутагтын төрсөн газар, Өнө өглөгт хийд
 - Халтарын балгас
- ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошуутай хиллэдэг Бичигтийн боомттой.

I ГУРАВ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ШИЛДЭГ ГАЗРЫГ ХӨГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТ



Суманд аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлэх нь орон нутгийн ард иргэд, бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээ байнгын эргэлтэнд орох, ажлын байрыг тогтвортой тогтмол байлгах ач холбогдолтой. Тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг хангах хамгийн боломжит нөөц юм. Орон нутгийн иргэдийн ажиллаж амьдрах орчныг сайжруулж, мэргэжилгүй болон хагас мэргэшсэн ажиллах хүчийг чадавхижуулж, орон нутгийн байгаль, нийгэмд үзүүлэх шууд ба шууд бус нөлөөллийг эерэг болгох боломжтой. Тогтвортой аялал жуулчлалыг амжилттай хөгжүүлсэн жижиг хот, тосгоны туршлага дэлхийн улс орнуудад олон бий.

Аялал жуулчлалд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхийн тулд хамгийн нөөц боломж сайтай, зарим тохиолдолд тухайн газрын цорын ганц хосгүй онцлогийг тодруулан гаргаж ирэх замаар маркетинг хийж брэнд дүр төрхийг хөгжүүлэх боломжтой байдаг. Сүхбаатар аймгийн хувьд Дарьганга сумыг тус аймгийн АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БҮС болгох боломж, нөөц баялаг байна гэж дүгнэсэн. Мөн Эрдэнэцагаан сумыг ДЭД БҮС болгож хөгжүүлэх боломжтой, харин маркетингийн хувьд ялгаатай байх юм.



ДАРЬГАНГА – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БҮС


- ГАНГА НУУРЫН ШУВУУ АЖИГЛАХ ТӨВ
- ЗЭГСТ НУУР – ЭРГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ
- ХҮН ХӨРӨГ – ГАЛЕРЕЙ
- АДУУНЫ ӨВ СОЁЛ – МУЗЕЙ
- ДАРЬГАНГА УРЛАЛЫН ТӨВ
- НЬЮ ДАРЬГАНГА – ОЛОН УЛСЫН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ЗУСЛАН
- АГТАНА ХҮРЭЭТ – ӨВЛИЙН НААДАМ

ЭРДЭНЭЦАГААН – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД БҮС

- БИЧИГТИЙН БООМТ – ХИЛ ДАМНАСАН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ
- ЛХАЧИНВАНДАД – ХИЛИЙН БҮСИЙН АЯЛАЛ
- ӨНӨ ӨГЛӨГТ ХИЙД – ЭРГЭЛ МӨРГӨЛ, ШАШНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ
- ЗОТОЛ ХАН УУЛ – МАЙХАНТ ОТОГИЙН БҮС

3.1 ДАРЬГАНГА – АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БҮС БАЙГУУЛАХ МЕНЕЖМЕНТ

ГАНГА НУУРЫН ШУВУУ АЖИГЛАХ ТӨВ



(45°15'N; 113°59' E, д.т.д 1294м, нуурын талбай 200га, урт 2.1 км, дундаж өргөн 1км, дундаж гүн 1.5м)

Сүхбаатар аймгийн Дарьганга сумын хамгийн шилдэг газруудын нэг нь **ГАНГА НУУР** бөгөөд сүүлийн үед Дотоодын жуулчдын анхаарлын төвд орж ирсэн ШУВУУ АЖИГЛАХ сонирхол чиглэлээр хөгжүүлэх боломжтой. Энгийн аялагч иргэд ан амьтан, жигүүртэн шувууд, хорхой шавьж, эрвээхэй, цэцэг харж баясах, асууж лавлан танин мэдэхийг зорьдог хандлагатай болсон учир Ганга нуурын орчинд “шувуу дурандах” байр, нуувч, тавцан зэргийг байгуулах боломжтой.

Ганга нуур, түүний орчин нь олон улсын хэмжээнд ховордсон шувуудын үрждэг болон нүүдлийн үедээ бууж амардаг чухал нутаг гэдэг нь тогтоогдож 2004 онд “Рамсарын конвенцийн жагсаалт”-д бүртгэгдсэн. Дуут, Зэгст, Баянбүрд, Намжилбүрд, Устбүрд, Эрдэнэ, Сүмт, Ганга, Холбоо, Хошмог зэрэг олон нуурууд нь шувуудын “диваажин” болдог.

2012, 2015, 2018 оны мэргэжлийн шувуу судлаачдын хээрийн судалгааны тайлангаас үзвэл, Ганга нуурын орчинд 16 баг, 39 овгийн 108 төрөлд хамаарах 198 зүйл шувуу бүртгэгдсэн нь Монгол оронд тохиолддог нийт шувуудын зүйлийн 40 гаруй хувийг эзэлжээ. Монгол оронд бүртгэгдсэн өндөглөдөг 254 зүйл шувуудын 55% нь Ганга нуурын бүс нутагт тохиолдож байна. Бүс нутгийн хэмжээнд ховор ангилалд орсон 11 зүйл, олон улсын хэмжээнд ховор ангилалд багтсан 18 зүйл шувуу бүртгэгдсэн байна.

Сүүлийн жилүүдэд Ганга нуур орчмын экосистем мэдэгдэхүйц доройтож, нуурын усны талбайн суурь хэмжээ 12% багассан байна. Экосистемийн хувьд эмзэг, жижиг нуур учраас уур амьсгалын өөрчлөлт, хуурайшилт, агаарын хэмийн ихсэлт, хур тунадасны дутмагшил, ууршилтын нэмэгдэлт зэрэг нь гол нөлөө үзүүлж байгаагийн зэрэгцээ хүний сөрөг нөлөө, ган гачигийн улмаас усан дахь бичил организм дагаж өөрчлөгддөг. Тийм учраас экосистемийн өөрчлөлт, шувуудын судалгааг тогтвортой хянаж байх шаардлагатай.



ЗӨВЛӨМЖ:

- Экологи, биологийн оюутан залуучуудын дадлага, эрдэм шинжилгээний ажил, эрдэмтдийн ажиглалт судалгааг дэмжих, ажил хэргийн үүлзалт семинар зохиох
- Зэгс шагшuurгыг хамгаалах, завины зугаалга хөгжүүлэхээс татгалзах, шувууд дайжихгүй байх нөхцөлийг бүрдүүлэх
- “Монголын шувуу судлалын төв”-тэй хамтран ажиллаж хамгаалалт, менежментийн чиглэлээр зөвлөмж авах
- Ганга нуурын эрэгт аялагчдад зориулсан шувуу дурандах тавцан, холоос ажиглах нүүвчүүдийг барьж тохижуулах, шувуудын тухай мэдээллээр хангах.
- Машины зогсоолыг нуувч, тавцангуудаас хойш чиглэлд тодорхой зайнд байгуулж тэмдэг тэмдэглэгээ хийх



ХУНГИЙН ЧУУЛГАН: Гангар хун [Cygnus cygnus] Дарьгангын БЦГ-ын Холбоо, Зэгст, Дуут зэрэг нууруудад жил бүр үрждэг. Хавар нүүдлийн үедээ хамгийн эрт ирдэг шувуудын нэг бөгөөд жил бүрийн 3 сарын дунд гэхэд ирсэн байдаг. Намрын нүүдлийн үедээ Ганга нууранд 3500 – 4200 хүртэл тоогоор цугладаг бөгөөд 11 сарын эхэн хүртэл нууранд байршдаг.

ЗӨВЛӨМЖ:

- “Хунгийн чуулган үзэх аялал”-ыг жилд 2 удаа буюу хавар 5-р сард, намар 10-р сарын дундуур зохион байгуулж болно.
- Аяллын хөтөлбөрийг мэргэжлийн тур операторын туршлагатай баг хамт олонд даатгах, эсвэл орон нутгийн тур оператор компани зохион байгуулах нь зөв болно.
- Ихэвчлэн хосууд, залуучууд зорьж ирдэг учир тэдэнд зориулсан хөтөлбөрийг jointe дотоодын аяллын платформ, UB comedy, Монголын бартендерийн холбоо, Шувуу судлалын төв гэх байгууллагуудтай хамтран зохион байгуулах.
- Энэ үеэр Гангар хун жуулчны бааз нь бүрэн хүчин чадлаараа ажиллах

ГАНГАР ХУН жуулчны бааз нь 76 ортой бөгөөд нэг ээлжиндээ 100 хүртэл хүнийг хүлээн авах хүчин чадалтай учир нэмж шинэ бааз барьж байгуулах шаардлагагүй гэж үзэж байна. Тус баазын үйл ажиллагааг нь сайжруулах, стандарт мөрдүүлэх, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх зэргээр дэмжиж улирлынхаа хугацаанд нэг өдрийн ч алдагдалгүй ажиллах маркетинг менежментийн бодлого хэрэгтэй.



| ЗЭГСТ НУУР – ЭРГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Дэлхийд маш том байр суурь эзэлдэг НУУРЫН ЭРГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ нь Монголын аялагч жуулчдын хувьд ч хамгийн түрүүнд, хамгийн олноор сонгодог сонголт юм. Монголчуудын гадаад руу чиглэсэн аялалд Хайнан, Бали арлын далайн эрэгт очих аялал хамгийн ихээр борлуулагддаг бол дотоодод Хөвсгөл, Буйр, Увс, Хяргас, Өгий нуурын эргүүд аялагч жуулчдаар дүүрдэг. Дэлхийд Канад улсын Симсон нуур нь хамгийн шилдэг менежмент бүхий “нуурын эргийн аялал жуулчлал”-ыг хөгжүүлж тэргүүлсээр ирсэн.

Нуур нь хэн нэгэн жуулчин хаа нэгтээгээс зорьж ирснээр “Аялал жуулчлалын газар” болдог. Тэр хүртэл тухайн орон нутгийнхаа газрын зураг дээр нэг цэнхэр цэг л байдаг. Нуурын орчныг “Аялал жуулчлалын бүс” болгож хөгжүүлэхэд орон нутгийн удирдлагууд, аялал жуулчлалын менежерүүд, ард иргэдийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт шаардлагатай.

ЗЭГСТ НУУР нь 45°17'N; 113°50' E солбицолд д.т.д 1236м өндөрт оршдог. Нуурын талбай 0.25 га, үрт нь 1 км, дундаж өргөн 0.25 км, дундаж гүн 0.7м, эргийн үрт 1.4 км. ЭРГИЙН БҮС болгон хөгжүүлж аялагч жуулчдыг татах боломжтой. Харьцангуй жижиг хэмжээтэй нуур учраас нөөц даацыг бодолцон зөвхөн НАРАН ШАРЛАГЫН ГАЗАР, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ байгуулах төлөвлөлт хийхэд болно гэж үзэж байна. Нуурын эрэг дэх тохижилт нь жуулчдыг аяндаа өөрөө даллан дууддаг.

Дарьганга суманд 2020 онд 23000 жуулчин ирсэн дүн мэдээ бий. Энэ нь 2020 онд Буйр нуур руу ирсэн жуулчдын тоотой адил байгаа нь “боломж” байгааг нотлон харуулж байна.



ЗӨВЛӨМЖ:

- Зэгст нуурын элсэн эрэгт 3S буюу эрэг, элс, нар (Sea, Sand, Sun) наран шарлагын бүс байгуулах.
- Сумын ИТХ, ЗДТГ-аас ЗЭГСТ НУУРЫН ЭРГИЙН БҮС-ийг хөгжүүлэхийг бодлогоор дэмжиж, чадамжтай хувийн хэвшлийн байгууллагад газрын зөвшөөрөл олгож дундын өмчлөлийн хувьцаа эзэмшигч хамтарсан компаний загвараар хөгжүүлж, эдийн засгийн удаан хугацааны ашиг хүртэх хэлбэрээр оролцох
- Нуурын эмзэг эко нөхцөл байдлыг бодолцож нэгээс илүү байгууллагад газар олголт хийхгүй байх бодлого баримтлах
- Наран шарлагын орнуудыг 20 ба түүнээс дээш тоогоор байрлуулах, чанартай, үзэмжтэй, удаан эдэлгээнд анхаарах
- Саравчин дээвэртэй задгай асар байгуулж түргэн хоолны газар, амттан худалдаалдаг кофе шоп, усанд сэлэлтэнд хэрэгтэй жижиг хэрэгслийн дэлгүүр, мини супермаркет, түрээсийн үйлчилгээний газрыг байгуулах. Өдөржин усанд сэлэх зорилготой ирсэн жуулчид нуурын эрэг дээрх наран шарлагын газар, усан дээрх тоглоомоор зугаацангаа өдрийн хоолоо голдуу эрэг дээрх түргэн хоолны газарт идээд оройдоо бааз руугаа буцдаг гэдгийг анхаарах
- Завины зогсоол байгуулж төлбөртэй үйлчилгээ зохион байгуулах. Завь нь сэлүүрддэг каноэ, каяак, рафть, эсвэл хөлөөрөө жийх зориулалттай катамарин завь байх ба жижиг нуур учраас моторт завь тохиромжгүй.
- Усан дотор тодорхой гортиг татаж усан дээрх резинэн тоглоомын талбай байгуулах. Усанд сайн сэлж сураагүй хүмүүст зориулсан хийлдэг цагираг, хөвөгч гудас, хантааз зэргийг түрээсийн үйлчилгээнд гаргаж болно.
- Сүүдрэвчүүд, задгай ширээ сандал, хуурай технологитой 00, хог хаягдлын цэг, машины зогсоол, усны хувцас солих орчин, гар бөмбөгийн талбай, элсний тоглоомын талбай зэргийг зураг төслийн дагуу барьж байгуулах
- Түрээсийн үйлчилгээнд дугуй, MTV, UTV, хийлдэг завь, каноэ завь, каяак завь, катамарин завь, агаарын теннис, ширээний теннис, волейболын бөмбөг гэх мэт хэрэгслийг хангах
- Массаж үйлчилгээ нээж болно. Гадаад орнуудын нуур, далайн эрэгт нэвтэрсэн үйлчилгээ боловч Монголд цөөн хэдэн бааз, ресортуудад байдаг. Тус үйлчилгээг монгол гэр бариад эрхэлж болно.
- Эрэг дээрх шорлог, шар айраг, коктейль баарны үйлчилгээг “эргийн тек” хэлбэрээр ажиллуулах



- Нуурын эрэгт өндөр цамхаг босгож болно. Энэ нь аялагч амрагчид өөрсдийнхөө зургийг авах, нар мандах шингэхийг харах, усны мандлыг өндрөөс харах, тайвшрал бясалгалыг олж авах, шувуу дурандах гэх мэт үйлдэлд зориулагддаг.
- Дараагийн үе шатанд өвлийн эвент хөтөлбөр хэрэгжүүлэх. Цанаар гулгах, нохойн чарга ба морин чаргаар аялах, тэшүүрээр гулгах, хоккей тоглох, мөс мөргөлдүүлэх, “цас мөсний баяр”-ын хүрээнд мөсөн дээрх олс таталт, мөсөн дээрх сумо, мөсөн дээрх дугуйн уралдаан, шинэ жилийн баяр, цасан өвгөн бүтээх уралдаан, мөсөөр хотхон байгуулах, мөсөн дээрх бүжгийн үдэшлэг, галын наадам, мөсөн дээрх ширээ засалт, хоолны тэмцээн, өвлийн хувцасны шоу, мөсөн дээрх худалдаа зэргийг зохион байгуулж болно.
- Хэрвээ нуурын орчинд “аюултай” гэж үзсэн бүс байгаа бол “сэрэмжлүүлэх”, орохыг, явахыг хориглосон тэмдэг тавих, нуурын эрэг, хөвөөний цэвэрлэгээний ажлыг тогтмол хийх
- Хамгийн ашиг орлого авчирдаг үйлчилгээ бол хоолноос гадна ундаа ус, шүүс, дарс, шар айрагны үйлчилгээ байдгийг анхаарах.
- Хамгийн их жуулчдын үрсгалтай үед УСАН ФЕСТИВАЛЬ зохион байгуулж болно. Каноз завины уралдаан, хөвөгч цагирагтай сэлүүрдэх уралдаан, хөвөгч гудастай сэлүүрдэх, элсээр баримал бүтээх тэмцээн, усан доторх волейболын тэмцээн, усны шувуудыг таньж нэрлэх тэмцээн, усны хувцастай сайхан аялагч жуулчин шалгаруулах тэмцээн ... гэх мэтээр хөтөлбөрийг сэдэж хөгжүүлж болно.



НУУРЫН ЭРГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ нь улирлаар хязгаарлагддаг тул тухайн нуур, голыг амраах зав чөлөө өгдөг онцлогтой. Орчинд нь явган аяллыг хөгжүүлснээр иргэдийн байгальд хандах зөв хандлагыг дээшлүүлдэг ач холбогдолтой юм.



| ХҮН ХӨРӨГ – ГАЛЕРЕЙ

Монголд нийт 731 хүн хөшөө бий. Тэдгээрээс дундад зууны Монголд хамаарах хүн чулуун хөшөө 8 аймагт 74 байдаг ба түүний 59 нь дангаараа Сүхбаатар аймагт байдаг учраас тус аймгийг ХҮН ХӨШӨӨНИЙ ГАЛЕРЕЙ гэж хэлж болно. Мөн Сүхбаатар аймгийн хүн чулуун хөшөөд нь тэр чигээрээ ГАЙХАМШИГ, тэр чигээрээ УРЛАГИЙН БҮТЭЭЛ юм. Аливаа чулуун дурсгал тухайлбал, буган хөшөө, хүн чулуу, гэрэлт хөшөө, булш хиргисүүр нь тухайн газар орон нутгийнхаа “мөнхийн харуул” байдаг төдийгүй одоогийн хүмүүсийг өвөг дээдэстэй нь холбож байдаг нарийн учир хэлхээтэй сахиус юм. Хүн хөрөгүүд нь “биднийг үншиж мэдээрэй” хэмээн өвөг дээдсээс үлдээсэн “чулуун судар” билээ. Сүхбаатар аймгийн нутаг даяар “судар” болж үлдсэн хүн хөрөгүүд нь он цагийн аясаар элэгдэж, зарим нь хэн нэгний оролцоотой байрнаасаа хөдөлж, ганц хоёр нь УБ хотын музейд зөөгдөж байна. Өвөг дээдсийн сүнс, байгаль эхийн хэвлийтэй салшгүй холбоотой “хүн хөрөг”-үүдээ байрнаас нь хөдөлгөхгүйгээр хамгаалж, хаана ямар дурсгал байгааг нутаг орны иргэд, цаашлаад аялагч жуулчдад таниулах нь оюун санааны томоохон дархалсан хамгаалалт болох юм. Тийм учраас яаралтайгаар байршуулыг дахин баталгаажуулж, хөрөгүүдийг хуулбарлан бүтээж авах, бод мал болон зарим муу санаат хүмүүсээс хамгаалахын тулд хашаалан хамгаалах нь чухал байна.

Дарьганга сум, Дарьгангын БЦГ-ыг Сүхбаатар аймгийн АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЦОГЦОЛБОР БҮС болгох саналыг дэвшүүлсэн бөгөөд энэ бүсийн хамгийн чухал үзмэрийн нэг нь **ХҮН ХӨРӨГ - ГАЛЕРЕЙ** байх юм. Галерейг Дарьганга сумын нутагт Алтан-Овооны зүүн бэлд орших “Хөрөгийн хөндий” буюу “Хаан, хатан, хүү, бэрийн хөрөг” орших газарт байгуулах нь хамгийн зөв болох болов уу. Хүн чулуун галерей нь Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын чухал брэнд бүтээгдэхүүн болно гэдэгт итгэлтэй байна.



ЗӨВЛӨМЖ:

- Галерей нь задгай байх үү, эсвэл ямар нэгэн байшин барилгатай байх үү гэдгийг судлаачид, мэргэжилтнүүдтэй хамтран шийдэх
- Сүхбаатар аймгийн хэмжээнд хадгалагдаж буй бүх хүн хөшөөдийн хуулбарыг галерейд байрлуулан, онцлог, домог түүхээр нь баяжуулан тайлбар хийх.
- Элсэн занар, боржингоор урласан хүн хөрөгүүдээс хамгийн их элэгдэл хорогдол, эвдрэлтэйг нь соёлын өвийн мэргэжилтнүүдтэй зөвлөн галерейд органилаар нь авч хадгалах, оронд нь хуулбарыг нь байгальд үлдээх
- Бат бөх чулуугаар бүтээгдсэн, тухайн газартаа үнэ цэнэтэй гэж үзэж буй хүн хөрөгүүдийг яаралтай хашаалан хамгаалах, хашааг алсуур, дотроо зайтайгаар, нэг стандарт хэмжээтэйгээр, нэг ижил өнгө төрхтэйгөөр байгуулах. Баруун аймгууд дахь хүн хөшөөг хашаалсан байдал нь эдүгээ байнга шүүмжлэл дагуулдаг гэдгийг анхаарах
- Хашаалсан хүн хөрөгүүдийг түүхийн сурвалж, судалгааны тайлантай нь тулган зүг чиг, байрлалыг зөв болгон засаж, тасарсан толгойг нь байрлуулж сэргээн засварлуулах, тухай бүрийн тайлбар самбарыг байрлуулах
- Хүн хөрөг галерейг үзэх тасалбарын үнийг тогтоох, зар сурталчилгааны тусгайлсан маркетинг хэрэгжүүлэх
- Хүн чулуунуудыг баримтжуулсан ном бүтээл хэвлүүлэх
- Хүн хөрөгүүдийг газар дээр нь очиж үзэх боломжтой “аяллын маршрут”-ыг төлөвлөх, самбар байрлуулах. Улмаар “АРХЕОЛОГИ ТУР” болгон дэлхийн аялал жуулчлалын эргэлтэнд оруулах



| АДУУНЫ ӨВ СОЁЛ – МУЗЕЙ

Дундад зууны сүүл хагаст газар газраас цугласан адуун сүрэг Монголын зүүн бүсийн хялганат тал хээрт идэж улмаар Сүхбаатар аймгийн унаган агт морьд болсон түүхтэй. Адуугаа хурааж айраг цагаа исгээд байдаггүй, унага нь эхийн сүүгээр бойждог онцлог нь Сүхбаатарын адуу хурдан байхад нөлөөлсөн гэдэг. Дарьгангын жижиг зээрд, орлой, тожингууд, Ширээтийн цагаан адуу зэрэг нь танигдсан угшил юм. Өвгөн ноён Хардэл жанжин бэйс Пүрэвжаваас үлбаалж ирсэн адуугаа Сүхбаатарчууд үргэлж сайжруулж ирсэн түүхтэй.

1930-аад оны сүүлчээс тус аймгийн Мөнххаан, Өлзийт, Уулбаян, Дарханхаан, Сүхбаатар сумдын уяачид төрийн наадамд хурдан хүлгүүдээ сойх болсон бөгөөд олон нэртэй уяачид Галшар, Ёст, Орлойн хурдан удамт хүлгүүдээ цулбуур өргүүлсэн байдаг. 1940 – 1953 онд тус аймгийн 6 насны 36 хүлэг төрийн наадамд цулбуур өргүүлэн “Түмэн эх”-ийг дуудуулсан нь Монгол орон даяар гайхагдсан түүхтэй. Түүний 6 нь түрүүлж, 14 нь аман хүзүүдэж, 7 нь айргийн гуравт, 6 нь айргийн дөрөвт, 3 нь айргийн тавд давхиж ирсэн нь ямар ч аймгийн түүхэнд байхгүй амжилт юм.

- 1940 онд Ардын хувьсгалын 19 жилийн ойн баяр наадамд 30 айраг, түрүүний 10 нь дангаараа Мөнххаан сумын уяачдын хүлгүүд хүртэж, нутаг орон, адууныхаа чансаагаар халх даяар алдар нэрээ дүүрсгасан.
- 1943 оны 22 жилийн ойн наадамд Сүхбаатар аймгийн 10 хурдан хүлэг түрүү магнай, айргийн тавд хурдалж, өмнөх амжилтаа дахин бататгасан байдаг.
- 1944 онд 1 хүлэг нь айрагдсан бол 1947 онд Ардын хувьсгалын 26 жилийн ойн төрийн наадамд 4 хүлэг айрагдсан ба 4-үүлээ Дарханхаан сумын хурдан хүлгүүд байсан нь сонирхолтой.
- 1948 онд Сүхбаатарын 3 адуу айрагдсан бол 1951 онд Ардын хувьсгалын 30 жилийн ойгоор 5 хүлэг нь айрагджээ.
- 1953 онд 2 адуу нь айрагдаж, нэг адуу жороо морины уралдаанд айрагдсанаар нийт 36 удаа цулбуур өргүүлж, уяач, унаач, уугуул нутгийнхаа магнайг тэнийлгэж байсан гайхамшигт түүхтэй юм.


Өвгөн ноён Хардэл жанжин бэйс Пүрэвжавын алдарт зандан хүрэн азарганаас эхлээд өнөө цагийн Нийгмийн хонгор, Медальт улаан, Холхоон зээрд, Гарьд халтар гэх мэт домог түүхт хүлгүүд Монголын хурдан морины түүхэнд мөнхрөн үлджээ. Эдгээр хурдан хүлгүүдийг алдаршуулан хөшөө бүхий цогцолборыг Дархан хаан уулын энгэрт байгуулсан. Нийгмийн хонгор нь нэгдэл нийгмийн нэр дээр аймаг сумын наадамд 18 удаа хол тасархай түрүүлсэн байдаг.

Сүхбаатар аймаг нь хурдан хүлгүүдээрээ өнгөрсөнд ч, өнөө цагт ч гайхалтай түүх бүтээсэн хэрнээ энэ бүгдийг хүүрнэн өгүүлэх музей, ямар нэгэн үзүүлэг байхгүй байна. Тийм учраас “Дарьганга – аялал жуулчлалын цогцолбор бүс”-д Сүхбаатар аймгийн хурдан хүлгүүд, адууны өв соёлыг сурталчлан таниулах **АДУУНЫ ӨВ СОЁЛ МУЗЕЙ** байгуулах нь чухал байна.



ЗӨВЛӨМЖ:

- Мүзейг байгуулах газар, барилга байгууламжийн зураг төслийг сонгон шалгаруулалтаар шийдвэрлэх
- Мүзейн барилгад үзэгч жуулчдын ая тав тухыг хангасан хүлээлгийн хэсэг, угтах хэсэг, гар тээш хадгалах савнууд, хувцасны өлгүүр, түр амрах орчин, уулзалт семинарын танхим, кофе шоп, орчин үеийн 00... гэх мэтийг байлгах
- Сүхбаатар нутгийн хурдан хүлгүүдийн түүхийг дэлгэрүүлэн холбогдох материалыг цуглуулж үзүүллэг болгох
- Адууны гарал үүсэл, адууны тоног хэрэгслийн үүрэг зориулалт, эмээл, хазаар, үналга ачилганы хэрэгсэл, ташуур, бугуйл, үурга, адууны тамганы төрөл ба үр хийцүүдийг дэлгэн үзүүлэх
- Унага тамгалах ёс, тамга уламжлах ёс, хурдан морины уралдаан, хурдан морь шинжих ёс, хурдан морины эдлэл хэрэглэл, адууны тэнгэр, гийнгоо зэргийг тайлбарлан харуулах
- Адуутай холбоотой олдворууд, адууны сүг зургийн дүрсгалууд, адуу хойлоглох ёсыг таниулах
- Галшар, Тэсийн гол, Дархад, Үзэмчин, Барга, Орлой гэх мэт адууны омог үүлдрийн ялгаа, Дарьганга, Батноров, Далайчойнхор, Хүрээ, Ноён Сэврэй зэрэг урлал хийцийг үзүүллэг болгох... гэх мэт



| ДАРЬГАНГА УРЛАЛЫН ТӨВ

Монголын дүрслэх урлаг, уран дарханы түүхэнд Дарьганга нутгийн ард түмний оруулсан гайхамшигт хувь нэмэр бол Монгол даяар алдартай ДАРЬГАНГЫН МӨНГӨН УРЛАЛ юм. Манжийн эрхшээлийн үед Дарьгангын сүрэгчин хошуунд цалин цагаан мөнгөөр цалин пүнлүү тавьж олгодог байснаас энэ нутагт мөнгө элбэг болсон гэдэг. Тэрхүү мөнгөөр эдлэл хэрэглэл, гоёл чимэглэлийн зүйл хийх нөхцөл бүрдэж өөрийн гэсэн урлал чимэглэлийн онцлог, өнгө хэлбэрийг агуулсан хаана ч дахин давтагдахгүй хийц хөгжиж ирсэн.

Дарьганга нутагт 1800 – 1970 оныг хүртэл 170 жилийн хугацаанд 20 гаруй алдар цуутай дархчууд төрөн гарсан. Тэдний авъяас, бурхан ухаан, уран гар, хурц сэргэлэн нүд нь Дарьганга хийцийг бий болгож Монгол даяар алдаршуулсан түүхтэй. Дарьгангын нэрт дархчуудын мөнгөн урлалын 300 гаруй сод бүтээл байдаг байна.

Мөнгөн эмээл, хазаар, хударга, хэт хутга, аяга, сам, дарлага, бөгж, бугуйвч зэргийг маш уран хийцтэйгээр шүр, тана, сувд шигтгэн урладаг. Хээ угалзны дан болоод давхар сүлжээ, хаж, самнаа, хөдөлгөөнт луу, цэцэг, навч, эрвээхэйг үхаж сийлбэрлэн гаргадаг онцлогтой. Ардын домог, үлгэрийн сэдэвт амьтад, ургамлын дүрст хээ угалзыг чөлөөтэй зураглан, хэдэн давхар хөөж сийлбэрлэдэг нь “Дарьганга хийцийн амин сүнс” юм.

Дарьганга эхнэрийн гоёл чимэглэл зүүлтэнд нийтдээ 100 орчим том жижиг шүрэн шигтгээ оруулан цэвэр мөнгөөр дан, давхар нарийн үтсаар хослуулж, зарим тодотгох хэлбэр дүрсийг алтаар шарж урладаг онцгой нарийн үр ухаан шаарддаг цогц урлал юм. Эхнэрийн бүрэн гоёл чимэглэлд нийт 20 гаруй нэр төрлийн зүүлтийг дан мөнгөөр урладаг.

Энэхүү гайхамшигт өвийг сэргээх, одоо мэдэгдэж байгаа нөөцийг түшиглэн хөгжүүлэх, залуу хойч үед өвлөх сонирхлыг бий болгох, улмаар аялал жуулчлалын нэг бүтээгдэхүүн болгон хөгжүүлэх боломж байгааг онцолж **ДАРЬГАНГА УРЛАЛЫН ТӨВ**-ийг байгуулж аялагч жуулчдад бүтээлүүдийг худалдах, сурталчлан таниулах маркетинг хэрэгжүүлэх хэрэгцээ байна. Мөнгөн аягагүй айл гэж байхгүй, аялагч жуулчид Сүхбаатар нутагт жинхэнэ дарьганга хийцийн аяга, өөр бусад урлалыг худалдан авахыг үгүйсгэхгүй юм.





ЗӨВЛӨМЖ:

- Байршлын хувьд Дарьганга сумын төвд цахилгаан, усны шийдэлтэй газарт байгуулах нь зөв болно.
- Дарьганга урлал хийдэг ахмад, залуу үеийн санаа бодлыг тусгах
- Урлалын төвд дархан хүнээс гадна зураач, хайчилбар хийдэг хүн, оёдолчин, хатгамалчин, сийлбэрчин, хөөмөлчин, калиграфчин, гэрэл зурагчин гэх мэт бүхий л гар урлаачдын төлөөлөл ажиллах ажлын байрыг бий болгох
- Жүүлчдын анхаарлыг татахын тулд гадаах орчны тохижилтыг хийж үүдэнд нь “гудамж” үүсгэн “зээл” ажиллуулах. Шашны болон хуучны эдлэл, бэлэг дурсгалын зүйлс зардаг хүмүүсийг төвлөрүүлэх
- Фото студи ажиллуулах, зураг авах, угаах, жаазлах үйлчилгээг бий болгох
- Урлалын төвд “дарьганга, халх, үзэмчин” хувцас өмсөж зураг авхуулах түрээсийн үйлчилгээг нээх, хувцас солих өрөөг толь бүхийгээр тохижуулах
- Урлалын төвд алдартай дархчуудын хөрөг, дарханы багаж хэрэгсэл, уран бүтээлээс дээжлэн танин мэдэхүйн үзүүлэг байдлаар байрлуулах
- Урлалын төвд “Сүхбаатарт үйдвэрлэв” бараа бүтээгдэхүүний тасаг нээж, нутгийн брэнд гар урлал, бэлэг дурсгал, хүнсний бүтээгдэхүүн худалдаалах
- Урлалын төвийн гадаах орчинд үзэмжтэй саравч сүүдрэвч зэргийг байгуулах, ногоон байгууламж хийх, зураг авхуулах хүмүүст тохиромжтой орчинг бүрдүүлэх

| НЬУ ДАРЬГАНГА – ОЛОН УЛСЫН ХҮҮХЭД ЗАЛУУЧУУДЫН ЗУСЛАН

Дарьганга сумын нутагт Зэгст нуурын дэргэд 1979 онд байгуулагдсан Пионерийн зуслан суурьтай амралтын бүс байна. Эдүгээ 6.6 тэрбум төгрөгийн өртөгөөр шинэчлэн барьж байгуулах төсөл хэрэгжиж ТӨҮГ болгон ажиллуулах юм байна. Байгаль орчны маш давуу байдалтай байгаа нь сонирхол татсан төдийгүй их хэмжээний хөрөнгө оруулалтаар шинэчлэгдэхээр болжээ.



Тус зусланг түшиглэн дотоодын болон олон улсын хүүхэд, залуучуудын зуслан зохион байгуулах боломжтой. Гадаадын төдийгүй УБ хотын хүүхэд залуучууд хөдөө орон нутгийн нүүдэлчин ахуй амьдралтай танилцах, гадаад хэлний мэдлэг дээшлүүлэх, олон найз нөхөдтэй болох, бусдаас суралцах, бие даах, адал явдалтай учрах сонирхол жил ирэх тусам нэмэгдэж байна. Зусланд англи хэлний яриа, харилцааны соёл, багаар ажиллах чадварт суралцуулах, хамтдаа идэвхтэй, эрүүл орчинд амрах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж болно.

Гадаад улс оронд олон жил ажиллаж амьдарсан, монгол хэл соёлоо мартах шахсан хүүхэд залуучууд, ӨМӨЗО-нд төрөлх Монгол нутагтаа ирж эх хэлээрээ түүх, соёлтой танилцах, монгол хэлээ сэргээхийг хүсдэг олон өвөрлөгч хүмүүс бий.

АНУ, Англи, Канад гэх мэт оронд олон улсын хүүхэд залуучуудад зориулсан “зуны зуслан” зохион байгуулдаг бэлэн түршлага, хөтөлбөрүүд байдаг. Сүхбаатар аймгийн БОАЖГ, хүүхэд, залуучуудын байгууллагаас “Англи хэлний багш нарын холбоо”, түр оператор компани, “Хилийн чинад дахь монголчууд” ТББ, олон улсын түвшинд үйл ажиллагаа явуулдаг залуучуудын байгууллагуудтай хамтран YOUTH SUMMER CAMP төсөл хэрэгжүүлэх боломжтой.

RICHMOND ARCHERY CLUB
PRESENTS

KIDS ARCHERY CAMP

JULY & AUG

RICHMOND ARCHERY
UNIT 150
6851 ELMBRIDGE WAY
RICHMOND

10 HOURS (5 DAYS PROGRAM, 2HRS PER DAY)
RECURVE ARCHERY, RANGE SAFTY, ARCHERY GAMES, FUN SHOOT, DRILLS, MINI ARCHERY TOURNAMENT & MORE

OPEN TO AGES 8-16 Y.O

\$210 PER CAMP TAX INCLUDED

HURRY! LIMITED SPACE

CALL FOR MORE INFO
604 338-3999
OR VISIT OUR WEBSITE
WWW.RICHMONDARCHERY.COM

ЗӨВЛӨМЖ:

- Нэг ээлж 7–10 хоногийн сонирхолтой хөтөлбөртэй байх
- Зохион байгуулалтын бүх эрсдэлийг тооцоолж, шаардагдах бэлтгэл ажлыг найдвартай хангах
- ТӨҮГ нь хувийн хэвшлийн байгууллагатай хамтран ажиллах
- Хамгаалалт, эрүүл мэнд, гал тогоо, багш нарын албууд, зуслангийн захиргаа, маркетингийн баг гэх мэт бүрэлдэхүүн ажилладаг гэдгийг анхаарах
- Хөтөлбөр маш сонирхолтой байх. Тухайлбал, “Амжилтын гараа – ододтой хамт”, “Цэвэр агаар – зумба фитнес” өглөөний дасгал, Puzzle adventure racing – гүйлтийн тэмцээн, Camps best songs 2013 – гадаад дууны тэмцээн, Nomadic expedition – хээрийн цай, майхантай аялал, Shooting stars – сагсан бөмбөгийн тэмцээн, Dance revolution – бүжгийн тэмцээн, Camp league – хөл бөмбөгийн тэмцээн, My lovely guitar - гитарын хичээл, Camp beauty – эрэгтэй, эмэгтэй шилдэг загвар өмсөгчдийг шалгаруулах, My portrait – зургийн дүгуйлан, Funny drawings – зургийн тэмцээн, Scary story – аймшгийн түүх ярья, Dream diary - зүүдний тэмдэглэл түүдэг галтай үдэш, Фото зургийн дүгуйлан, Just lucky darts – дартсын тэмцээн, Camp photo model - фото модель шалгаруулах тэмцээн, What is your theme - явган аялал, Shooting stars – сагсан бөмбөгийн аваргуудын үзүүлэх тоглолт, Дахин үулзахын ерөөл тавья - хаалтын ажиллагаа, Үдэлтийн үулзалт (амралтын сэтгэгдэл хуваалцах, дүрсгалын зураг татуулах) гэх мэт.
- Тусгайлан веб хуудас үүсгэж, байнга сурталчилж, жил бүр энэ зусланд явах сонирхол сэдлийг төрүүлэх, хүсэн хүлээдэг зуслан болгож хөгжүүлэх



| АГТАНА ХҮРЭЭТ – ӨВЛИЙН НААДАМ

Алдарт Шилийн богд хайрханы үрд бэлд голдоо зүрхэн хэлбэртэй жижиг толгой бүхий том хүрээ бий. Галт уулын хэв шинжтэй энэ хүрээн дотор Дарьгангын Ду ноён адуугаа түүж оруулан бүрэн эсэхийг бүртгэдэг байсан гэх хууч яриа байдаг. Тус Агтана хүрээтэд “өвлийн аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх зорилготой “Агтана хүрээт” наадам 3 жил дараалан зохион байгуулагдсан. Монгол Улсын 21 аймаг, Сүхбаатар аймгийн 13 сумын шилдэг хүлэг, адуучид аймаг сумаа төлөөлөн оролцдог. Наадмын хүрээнд Сүхбаатар нутгаас төрсөн энэ зууны энгүй хурдан хүлгүүдийг алдаршуулж, улс, бүсийн уралдаанд Сүхбаатар нутгийн нэрийг дуудуулж яваа алдарт уяач нарт хүндэтгэл үзүүлдэг уламжлалтай. 2020 оны наадмыг 3000 гаруй хүн зорин ирж үзсэн нь цаашид улам хөгжүүлж алдаршуулах боломжтой гэдгийг харуулж байна.



ЗӨВЛӨМЖ:

- Наадмын хөтөлбөрийг “Талын түмэн адуу” эвентээс онцлох ялгаатай байлгах
- Тусгайлан сошиал хуудас, менежментийн баг хөгжүүлэх, оюуны өмчийн патенттай болгох
- Наадмын нэршил, хугацаа, зохион байгуулагдах газрыг хөдөлгөөнгүй тогтоож, өөрчлөхгүй байх.
- Жил бүрийн наадмын тайланг гаргаж, аймаг, суманд үлдэж буй эдийн засгийн үр ашиг, алдаа оноог дүгнэдэг байх
- Жил бүр гадаад, дотоодын мэргэжлийн гэрэл зурагчид, сэтгүүлчид, олны танил инфлүүнсер, Монгол Улсад суугаа гадаадын элчин сайд нар, олон улсын байгууллагын ажилтнуудыг урьж үзүүлэх, тэднээр дамжуулан маркетинг сурталчилгааг хөгжүүлж олны хүртээл болгох
- Наадмын үеэр аюулгүй байдлыг хангах алба, эмнэлгийн баг, зохион байгуулалтын хүчирхэг баг ажиллуулж хэвших
- Наадмын нээлтийг цомхон, урт нуршуу үг хэлэлт, олон дарга нарын оролцоогүй зохион байгуулж хэвших
- Наадмын хөтөлбөрт дарьганга, үзэмчин дээл хувцасны соёлыг харуулсан үзүүлбэр, морь унуулах үйлчилгээ, адууны тамга бүхий тугт парад, морин поло, морь бугуйлдах тэмцээн, Сүхбаатарын брэнд, Дарьганга хийц урлал бүтээлийн үзэсгэлэн худалдаа, дуудлага худалдаа, урлагийн тоглолт, Сүхбаатарын хурдан хүлгүүдээр зургийн үзэсгэлэн, Дээлтэй монгол жаал – шалгаруулалт зэрэг бусад эвентээс ялгагдах хөтөлбөр хэрэгжүүлэх



3.2 ЭРДЭНЭЦАГААН СУМЫГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ДЭД БҮС БОЛГОН ХӨГЖҮҮЛЭХ МЕНЕЖМЕНТ

БИЧИГГИЙН БООМТ – ХИЛ ДАМНАСАН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ



Бичигтийн боомт нь Эрдэнэцагаан сумын нутагт 1992 онд нээгдсэн бөгөөд 2008 оноос байнгын үйл ажиллагаатай автозамын боомт болж өргөжсөн. БНХАУ талаас ӨМӨЗО-ны Шилийн гол аймгийн Зүүн үзэмчин хошууны боомт юм. Баруун-Урт хотоос 278 км, УБ хотоос 850 км зайд оршдог.

Тус боомтоор дамжуулан **“УБ – Сүхбаатар – Авга хошуу – Шилийн хот – Шанду хот – Бээжин /Эрэн/ – УБ”** аяллын маршрутыг хэрэгжүүлэх боломжтой. Дорнод аймгийн нутгаар дамжин Манжуурын аялал маш эрчимтэй явагддаг бөгөөд эл аялал нь Дорнод аймгийн эдийн засагт багагүй орлого авчирдаг шоппинг аялал юм. Харин Сүхбаатар аймгийн нутгаар явагдах эл аяллын хөтөлбөр түүхийн танин мэдэхүй ба худалдан авалтыг хослуулсан аяллын бүтээгдэхүүн байх боломжтой.

Аялал нь “Баруун-Урт хотын музей, Алтан-Овоо, Ганга нуур, Шилийн богд, Талын агуй, Зотол хан, Өнө Өглөгт хийд, Хөндлөн хайлааст, Лхачинвандад, Бичигтийн боомт, Авга хошуу, Бэлгүүдэйн соёлын хүрээлэн, Түүх соёлын музей, Авгын Эко хүрээлэн, Чингис богд уул, Шилийн хот, Эрдэнийн 13 овоо, Бэйсийн сүм, Юань гүрний музей, Шулуун хөх хошуу,

Малартын хийд, Хубилайн дээд нийслэл Шанду хотын туурь, Алтан урагийн тахилгат овоо, Долнуур, Бээжин, Цагаан хэрэм, Хөх хот, Эрэн, УБ” гэсэн маршрутаар явагдаж болно. Тус аялал нь 14-15 хоногт багтах бөгөөд Монгол – Хятадын хил дамнасан аялал жуулчлал юм. Аяллаар Сүхбаатар аймгийн хамгийн алдартай байгаль, түүхийн газруудыг үзэхээс гадна БНХАУ-ын нутаг дахь Монголын эзэнт гүрний түүхэнд холбогдох олон газруудтай танилцаж, Хятадын аялал жуулчлалын хурдтай өсөлтийг биеэр мэдрэх, тэднээс суралцах олон давуу талтай.

Мөн дээрх маршрутыг 3-4 хувилбар байдлаар өөрчилж аялах хоногийг багасгах боломжтой. Монголчууд гадаад руу чиглэсэн аялалд жилд 609 сая ам долларыг зарцуулдаг. Байгууллага хамт олноороо аялах, гэр бүл, хамаатан садангийн бүлгээр аялах сонирхол өндөр байдаг учраас тус аяллын хөтөлбөрийг боловсронгуй болгож байнга сурталчлан таниулж урсгалыг үүсгэх хэрэгтэй.



| ЛХАЧИНВАНДАД – ХИЛИЙН БҮСИЙН АЯЛАЛ



Монголын зүүн өмнө хязгаарыг тохинуулагч сайд Егүзэр хутагтад өвөрлөгч ноёноос 1886 онд бэлэглэсэн 2 буга эдүгээ Лхачинвандад уулнаа 600 орчим болж өсөхөд 100 гаруй жил урсан өнгөрчээ. “Лхачин – их тэнгэр”, “Вандад – асар их хүч чадал” гэсэн агуулгатай. Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумаас зүүн урагш 75км зайд орших Лхачинвандад уулын буга согоо, бор гөрөөс, илбэнх зэрэг амьтдыг хамгаалах зорилгоор 1965 онд улсын хамгаалалтанд авсан.

Зүүн урд хилийн зааг дээр орших тус уулын орчин, салбар уулс, уулс хоорондын хөндий, бэлийн хялганат хээр, буга согоо, ан амьтдыг Хилийн цэргийн ... дугаар ангийнхан хайрлан хамгаалсаар ирсэн. Монгол Улсын торгон хил, түүний зурвас, хилийн багана гэдэг бол ямар ч монгол хүний сэтгэл зүрхийг хөндөх сэдэв юм. Одоогийн байдлаар Монгол Улсын хойд хилийн зурваст орших Алтанбулаг, Орхон – Сэлэнгийн бэлчирийг аялал жуулчлалын эргэлтэнд оруулж хилийн застасаас тохижилт хийж, аялагчдаас хураамж авч орчны түүхийг сэргээж, эргэн дурсагдах хөшөө дурсгалыг байгуулж, аялагчдад зориулсан саравч сүүдрэвч, сандал ширээ байгуулсан байдаг. Мөн хилийн зурвас дурандаж харах боломж олгодог.

Мөн “Дорнод – Аялал Жуулчлалын Нэгдэл” ТББ-аас Дорнод аймгийн Хилийн цэргийн байгууллагатай хамтран Чойбалсан хотоос 80 км зайд орших хилийн зурвас, хилийн отряд руу “Монгол Улсын дархан хил” сэдэвт хүүхэд залуучуудын аяллыг 2017 – 2020 онд зохион байгуулж нийт 500 гаруй хүүхэд залуусыг цэргийн анги, хилчин цэргүүдийн өдөр тутмын амьдралтай танилцуулж, хилийн багана үзүүлж “эх оронч хүмүүжил” олгох, эх орноо хайрлах сэтгэлгээг нэмэгдүүлэх зорилгуудыг хэрэгжүүлдэг сайхан уламжлалтай.

Ирээдүйд Лхачинвандад уулнаа Хустайн нуруунаас тахь нутагшуулж, буга согооны хамтаар ан амьтдын диваажинг бүтээж, аялагч жуулчдад зориулсан хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой. Жуулчдад зориулсан хоол үндны үйлчилгээ, хөтчийн үйлчилгээ, авъяаслаг цэргүүдийн бүтээсэн гар урлалын бүтээл худалдах зэргээр баяжуулж болно.



| ӨНӨ ӨГЛӨГТ ХИЙД – ЭРГЭЛ МӨРГӨЛ, ШАШНЫ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТӨВ

“Тамгатай 13 хутагт”-ын нэг Егүзэр хутагтын 4 үе захирч байсан ӨНӨ ӨГЛӨГТ хийд нь Оросын II Екатерина хатан хааны нэгэн тосгон хотын бүтэц бүхийгээр баригдсан гэдэг. Монгол, япон, түвд, хятад, орос загварын барилгуудтай, өдөр бүр хурал ном, бүрээ бишгүүр, хэнгэрэг цангийн дуу нижигнэсэн, маш хөл хөдөлгөөнтэй хийд орон байжээ. Зүүн Монголын томоохон хийд бөгөөд Сэцэн хан аймгийн Хурц ван Түддэн засгийн хошуу одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын Номын дов хэмээх газарт 1780 онд байгуулагдсан. Өнө өглөгт хэмээх нэрийг II дүрийн Егүзэр Лувсанбалдан хайрлажээ.

Аялагчдад зориулсан “бүян хураах” хөтөлбөр хэрэгжүүлж болно. Тухайлбал, лам нарын цав бэлдэх, сүм хийдийн том хурлууд ба шашны эвент баярын үеийн бэлтгэл ажилд туслах, хийдийн хашаа хороо, хаалга үүд, эд хогшил, бурхан тахилыг цэвэрлэх, зулын гол ороох, цөгц цэвэрлэх, ном судар хүүлж бичих, номын баринтаг оёх, эрхиний бөөр зорох ба зүлгэх, эрхи хэлхэх, мод тарих, мод суулгах, суулгац тарих нүх ухах, мод услах, хийдийн түлээ мод хөрөөдөх, хагалах, аргал хомоол түүж бэлдэх, лам нарын суудал олбог оёх, эсгий ширдэг ширэх, лам дээл хувцас оёх, даллаганы үүт оёх гэх мэт.

Өнө өглөгт хийдийн түүхийг аялагч жуулчдад таниулах, хийдийн ойролцоо 300-500м зайд “эко гэр бааз” байгуулж бясалгал, эргэл мөргөлийн жуулчдыг хүлээн авдаг үйлчилгээ нээж болно. Хийдийн сахиусанд зориулсан зан үйлийг “шашны эвент” болгон хэрэгжүүлэх, аль болох Монголын бусад хийдүүдээс ялгарах шашны эвентийг бий болгох. Тухайлбал, Амарбаясгалант хийд “Гонгорын бумба тахих ёслол” үйлддэг. Чойрын хийд “Хүүхдийн овоо” тахидаг.



ЗӨВЛӨМЖ:

- Сумын ИТХ, ЗДТГ-аас нээлттэй үйл ажиллагааны бодлого хэрэгжүүлж хамтарсан менежмент, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжиж ажиллах, шашин мөргөл болон эрүүл мэндийн аялал жуулчлал чиглэлээр хослуулан хөгжүүлэх.
- Хэрэгжилтийг хийдийн дэргэдэх бизнес, менежментийн багт хариуцуулах
- Зочлох үйлчилгээ, бааз байгуулах менежмент, ариун цэврийн эко технологийн шийдлүүд, баазын тохижилтын стандарт, үйл ажиллагааны маркетингийн чиглэлээр тусгайлсан сургалтууд авах
- Эко бие засах газар /эрэгтэй, эмэгтэй, хүүхдэд зориулсан тусдаа/, гар угаах цэг, гал тогоо, хооллох танхим, гадаах орчны тохижилт, саравч сүүдрэвч, явган зам, тэмдэг тэмдэглэгээ, мэдээллийн самбар, ногоон байгууламж, гэрэлтүүлэг, авто зогсоол, хогийн хаягдлын цэг, шашны эдлэл хэрэглэлийн дэлгүүр, бясалгал хийх орчин гэх мэт агуулгуудыг зураг төслийн дагуу бүтээн байгуулах.
- Монголын ямар ч хийдэд хэрэгжээгүй зүйл бол “хувраг хөтөч”, “сүмийн хөтөч” байдаг. Монголын буддын шашин, бурхадын бэлгэдэл, үр хийц, Өнө өглөгт хийд, Егүзэр хутагтын талаар гүнзгий мэдлэгтэй хөтчийг тусгайлан бэлдэж зорьж ирсэн сүсэгтэн олон, аялагч жуулчдад газарчлан тайлбар хийдэг байх.
- Орчин үеийн монголчууд бурханд мөргөж залбирах, сүсэглэх, уул овоонд өргөл өргөх, овоо тойрох, 7 бурханд залбирах, цайны дээж өргөх гэх мэт зан үйлүүдийг бүрүү хийдэг, бүрүү үг хэлдэг талтай учраас бичил сургалтууд хэрэгжүүлж болно.
- Уламжлал анагаах ухаан суурьтай маарамбын газар ажиллуулж болно. Сүхбаатар аймгийн үгүүл хоол цайтай хослуулсан асаргаа, сувилгааны хөтөлбөрүүд хэрэгжүүлэх.
- Аялагчдад зориулан “сүм хийдийн газар биеэ авч явах журам” боловсруулан мөрдүүлэх.



| ЗОТОЛ ХАН УУЛ – МАЙХАНТ ОТОГИЙН БҮС

Эрдэнэцагаан сумын нутаг дахь хамгийн сайхан газруудын нэг бөгөөд тогтоцын хувьд онцгой. Дархан хан, Матад хан, Зотол хан гурван уулын домог түүх, “ХАТАГИНЫ НААДАМ”-ыг сурталчлан таниулж, зорьж ирдэг аяллын газар болгон хөгжүүлэх боломжтой. Зотол ханы овоог сүрдэм сайхнаар засах, алсаас харагдах орчинд “майхант отог” тохижуулах.



ЗӨВЛӨМЖ:

- Сумын ИТХ, ЗДТГ-аас Зотол хан уулын майхант отог байгуулах төсөл хэрэгжүүлэх, төсөвт суулгах
- Машины зогсоолын гортиг, замын тэмдэг тэмдэглэгээ, мэдээллийн самбар, майхант бүс, гал түлэх орчин, эко хуурай 00, сүүдрэвч, сандлуудыг зураг төслийн дагуу, байгалийн мод, чулуу ашиглан байгуулах
- Зотол хан уулыг хүндэтгэх, өргөл өргөхөд анхаарах “санамж” боловсруулж мэдээллийн самбарт байрлуулах
- Зотол хан уулын оройд гарах явган жимийг байгалийн материал ашиглан байгуулах
- Гурван жилд нэг болдог “Хатагины наадам” хөтөлбөрийг аялал жуулчлалын эвент, аяллын маршрут болгон сурталчилж таниулах, аялагч жуулчдыг татах маркетинг хэрэгжүүлэх





3.3 АЯЛЛЫН МАРШРУТЫГ БАЯЖУУЛАХ БОЛОМЖТОЙ БУСАД ЗОРИХ ГАЗРУУД

ДОНГОЙН ШИРЭЭ – АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛ

Ямар нэгэн балгас, булш хиргисүүр нь байгууламжийнхаа зориулалтаар бүрэн дүүрэн ашиглагдах боломжгүй ч соёлын болон түүхийн хувьд юугаар ч орлуулшгүй байдаг. V-VII зууны үед Монголын газар нутаг дээр ноёрхлоо тогтоож байсан Түрэгийн эзэнт гүрний түүхэнд холбогдох эл дурсгалыг монголчууд сайн мэдэхгүй билээ. Монголын нутагт Түрэгийн үед холбогдох онгон, тайлга тахилгын байгууламж Орхон голын сав, төвийн бүсээр тохиох нь элбэг. Түвшинширээ сумын нутаг дахь Донгойн ширээ дурсгалыг аялал жуулчлалын эргэлтэнд оруулах боломжийг алсдаа хэрэгжүүлж болно.

Олон улсын сайн жишээнүүд бий. Эл бунхан БНХАУ-ын Шаньси мужийн төв, эртний Хятадын нийслэл Шиань хотоос холгүй орших бөгөөд 2000 жилийн тэртээ Хятадыг нэгтгэсэн агуу удирдагч Цин Шинхуандигийн үе буюу МЭӨ 247 – 209 онд байгуулагдсан гэж археологичид үздэг. Өөрөөр хэлбэл, Цин Шинхуанди хаан ширээнд заларсан цагаас тэнгэрт халих хүртлээ бариулсан байна. Тус бунханг үзэхийн тулд 120 юань төлдөг. Жилд 140 сая жуулчин ирж үздэг бөгөөд 60 тэрбум долларын ашиг олдог БНХАУ-ын хамгийн шилдэг аялал жуулчлалын газар юм.

Түркийн шинэ чулуун зэвсгийн суурин Catalhoyuk хэмээх олдворт газрыг ил үзмэр бүхий музей болгосон жишээ.



| БАЯНДЭЛГЭР – ТҮВШИНШИРЭЭ

Байгалийн үзэсгэлэнт газрууд нь ер бусын байгалийн хүчин зүйлүүд болон хүрээлэн буй орчны нөлөөгөөр хэзээ ч хаана ч ахин давтагдашгүй цорын ганц хосгүй тогтоцтой байдаг ба дэлхий даяар тоолж баршгүй олон байгалийн үзэсгэлэнт газрууд бий. Жуулчид байгалийн үзэсгэлэнг харж баясах, их хотын амьдралаас холдох, олон хүнтэй газраас холдох, онцгой содон байгалийг өөрийн нүдээр харж мэдрэх гэж аялдаг. Сүхбаатар аймгийн **Онгон таван булаг, Хужирт, Дэлгэрхаан уул, Донгойн ширээ, Бударын чулуу, Таван толгойн дурсгал** гэх мэт газруудыг НЭГ МАРШРУТААР ХОЛБОЖ аялал жуулчлалын эргэлтэнд оруулах боломжтой. Байгалийн болон түүхийн өгөгдөл, агууламжтай газрууд учраас жуулчдад үзүүлж танилцуулах хэрэгтэй юм.

ОНГОН ТАВАН БУЛАГ: Баяндэлгэр сумын Хонгор багийн нутагт Онгон элснээс эх авч, элсэн дундуур урсан, элс хаван далд ордог үзэмж төгс Баруунбулаг, Гүнбулаг, Талбулаг, Зүүнбулаг, Дундбулаг гэсэн таван хэсэг булаг бий. Хайлаас мод бүхий ногоон хөв, хоёр эргийн мод нийлэлдэн хэсэгхэн зуур харанхуй орчин үүсгэдэг.

ХУЖИРТ: Тал нутагт хадат уулс, түүний хавцлууд яах аргагүй үзэмж нэмнэ. Олон хавцлын дундуур явган аялал хийх, түүхийн үл мөр хайх, хад чулууны тогтоц ажиглах, мод ургамлын судалгаа хийх, оройд нь гарч орчны байгалийг тольдох гэх мэтээр аяллыг баяжуулах боломжтой газар.

ШАР БҮРДНИЙ ЭЛС: Энэ газарт эртний хүний оромж байсан үл мөр байнга олддог байна. 1997 онд “Нүүдэлчний ардын хүрээлэн” ЭШХ болох үеэр оролцогч эрдэмтэд Шар бүрдний элсээр 15-20 минутын явган аялал хийх зүүрт хүн бүр эртний хүмүүсийн хэрэглэж байсан чулуун зэвсэг, сум, гурилын нүдүүр гэх мэт зүйлсийг олсон гэдэг. Хээрийн судалгааны үеэр бид нар ч бас эртний чулуун зэвсэг хийж байсан чулуудын хэлтэрхийнүүдээс олсон билээ.

ДЭЛГЭРХААН УУЛ: Түвшинширээ сумын нутаг дахь тус газрын хад чулууны тогтоц том том аргай тараагаад орхисон мэт сонирхолтой. 300 гаруй кв.км талбайгаар үргэлжлэх тэр их чулуун тогтоц дотор түүхийн ямар ч дурсгал хадгалагдаж байхыг үгүйсгэхгүй. Цагаан элэгний хадны зурагт түгээмэл тохиолддог янгир, адуу, хүний дүрслэл арай өөрөөр зурагдсан байдаг.



| БУДАРЫН ЧУЛУУ

Талын нэг тараагаад шидчихсэн мэт том том чулуун дундуур муруйж тахирлан явсаар Бударын чулуунд очдог. “Төөрдөг, төөрүүлдэг хад” ч хэмээн нэрлэнэ. Тэнд байх Шартын хад хэмээх хэсэг чулууг “Чингисийн цэрэг” гэдэг. Харин Бударын чулууны тэр олон чулууг “Хатагин овогтны цэргүүд” хэмээнэ. Энэ хоёр цэрэг хоорондоо байлдаж гэж байтал мөнх тэнгэр “та хэд ах дүү нар байтлаа бие биеэ хядах нь үү” гэж хилэгнээд чулуу болгоод хувиргачихсан гэдэг домогтой.

Бударын чулууны дүрслэл уран чамин. Адууг голдуу сэдэвлэсэн байх агаад нэг хүн морио хөтөлчихсөн явж байна. Хоёр хүн өндөр шатаар авирч байна. Нэг адуу шатны ирмэгээр дээшээ мацаж, доороос нь нэг морь шат өөд цоройчихсон зогсож байдаг. Ямар учиртай шатаар хаашаа яах гэж мацаж байгаа юм бол гэж асуухаар. Нэг эр хоёр салаа гэзэг унжуулсан хүүхнийг хэвтүүлээд үүлэн борооны ажил хийж байна. Бас нэг годойсон гэзэгтэй бүсгүйг нэг эр хөтлөөд гүйж явна. Зураг бүхэн сэдэвтэй, уран сэтгэмж, хошигнолд нь хязгаар гэж үгүй.

ХУЛГАЙЧИЙН ШАНД: Сондгой орших бөмбөгөр хэлбэртэй том хадан дотор хөтөлгөө морьтой хэдэн хүн багтчихаар гэрийн бүүринаас арай том хонхорхойтой. Монгол гэрийн зүүх байх хэмжээний газарт тохой орчим гүнтэй худаг гаргажээ. Гадна талаас нь хэн ч харахааргүй энэ хонхорхойд Торой бандиас эхлээд архаг шилийн сайн эрс хэдэн ч өдрөөр орогнож нуугдаж байсан гэдэг. Тийм учраас “Хулгайчийн шанд” гэж нэрлэжээ.



БУРХАНТ ХАД: Бурхант хадны өвөрт “нууц тарнийн дацан” байжээ. Галбын гурван хийдээс Хамарын хийд, Егүзэрийн хийдээр дамнаад энэхүү Алтан очиртын хийд хүрдэг жимтэй, улааны шашны урсгал хөгжиж байв. Эдүгээ зөвхөн “Өвгөн хурал”-ын дуганын түүрх үлдээд түүний дээр овоо босгожээ. Онгон сумын лам нар Бурхант хадыг тахиж овооны наадам хийж морь уралдуулдаг.

| ОНГОН ТАВАН ТОЛГОЙ

Онгон Таван толгойн дурсгал нь XIII зууны Их Монгол Улсын ихэс дээдсийн алтан ясыг онголсон халх Монгол төдийгүй алс хол орнуудын археологийн салбарт ч нэрээ дуурсгасан газар. Таван толгойн булшнаас эмэгтэй хүний “цагаан шонхор” сийлбэртэй алтан бөлзөг, гонзгой танан шигтгээтэй, шармал бадам цэцгэн суурин дээр тогтоосон алтан цэцгэнд суулгасан зууван том цагаан сувдан чимэг, хоёр үзүүртээ шижир алтан сийлбэртэй оюу чимэг олдсон. Таван толгойн дурсгалын зүүн хойд талд хөх туяатай цагаан гантигаар урласан исэр сандалд заларсан тэргүүнгүй хөшөөд буй.

Эхний хөрөг: Дээлийн энгэрийн хээ бүдгэрсэн хэдий ч дал мөрийг ороосон луу хээ нь тод үлдсэн. Мөрнөөс нь ханцуй руу лууны саврыг буулгахдаа хайрсыг нь маш нарийн “шаглаж оёсон” мэт уран сийлбэрлэж хийсэн нь гайхамшигтай. Малгайны залааг ар нурууны голоор товойлгон сийлсэн. Агсарганы толь дөрвөн дэлбээт зуувандуу цэцгэн хэлбэртэй. Исэрийн тохойловч дээр тавьсан зүүн гартаа эрхи барьсан. Ханцуйны нугалаас тод, бүсэнд дарагдсан дээлийн хуниас нарийн. Дээлийн хормойд хээтэй хошмог хийсэн, бойвыг тавцан дээр гишгэсэн. Гутлын нимгэвтэр үлтай хавтгай хоншоор дээлийн хормой дороос цухуйсан. Исэр сандал дээр барын арьс дэвсэж, бөмбөгөр түшлэгийг давуулсан, толгойг нь ар тийш унжуулан тохсон, хоёр бахим савар нь сүртэй унжсан, зантгар толгойн нүд бүлтгэр, хамар нь төвгөрөөс үзвэл барын арьсыг толгойн ястай нь хамт тавьсан мэт.

Хоёр дахь хөрөг: Цагаан гантиг хөрөгний цээжин бие тэр чигээрээ байхгүй. Дээлний бүсэлхийн шаглаас тод, агсарганы долоон дэлбээт цэцгэн толины хийц чамин. Агсарганы бөгжнүүд хээтэй, эрхи барьсан гарыг тохойловчны дотуур оруулж өвдөгний дотоод тал руу чиглүүлсэн. Баруун гарыг тохойловч дээр ил гаргасан. Хормойд гаргасан хошмог өвдөгнөөс доогуур, хормойн доогуур гутлын хоншоор цухуйсан. Исэр сандал дээр барын арьс тохохдоо толгойг урагш харуулж бойвд гишгүүлж, түшлэг дээгүүр бөгсөн талыг тохож арагш унжуулсан байдалтай, сүүлийг нь баруун тийш мушгируулж хийсэн.

Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйлийн бичигт “Жүн ван болвоос дэвсгэр ... өвөл өөрийн яам, гэр дор булгаар хажлуулсан шилүүс хэрэглэ. Улсын түшээ өөрийн яам, гэр дор ирвэс дэвсгэр хэрэглэ” гэж тусгайлан заасан байдаг. Гэтэл энд исэр сандал дээр барын арьс дэвсэж толгой дээр нь хөлийг гишгүүлжээ. “... Хан ... Ёст дээл болвоос 5 хумстай луу харгам хатгасан магнаг... хэрэглэ” гэж заасан байдаг. Мөн язгууртны дээлэнд мөр дагуулсан луу урласан байна. Тэгэхээр Сэцэн хан, Түшээт хан, Засагт хан, Сайн ноён хан гэсэн Чингисийн Алтан урагийн ноёдын дээл хувцасны чимэг сэлт нь Манж засаг болон Богд хаант засгийн үед тогтоогдсон зүйл бус, түүнээс ч эрт XIII зуунд ёслол төгөлдөр байжээ.



ДӨРӨВ. СҮХБААТАР АЙМАГТ ХӨГЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ АЯЛЛЫН ТӨРӨЛ

Жуулчид байгалийн үзэсгэлэнт газруудыг өөрийн нүдээр харах, их хотын амьдрал ба олон хүнтэй газраас түр боловч хол байх, онцгой содон байгалийн тогтоцыг мэдрэх зорилгоор аялдаг. Дэлхий даяар байгальд суурилсан аялал жуулчлалыг хөгжүүлж ямар ч аяллын төрөлд байгальд ээлтэйгээр ямар нэгэн “УЛ МӨР ҮЛДЭЭХГҮЙ” аялахыг уриалж байна. 2017-2018 оны судалгаанаас үзэхэд, дэлхийн жуулчдын нас залуужиж 15-29 насныхан нийт аялагчдын 33%-ийг эзлэх болсноос гадна “ан амьтантай танилцах аялал” хамгийн ихээр сонгогдсон байна. Энэ төрлийн аяллыг сонгосон жуулчдын 63% нь байгалийн үзэсгэлэнт газар болон үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээр аялсан бол 19% нь халим үзэх, 14% нь дельфин харах аялалд хамрагджээ.

4.1 ШУВУУ АЖИГЛАХ АЯЛАЛ

Шувууг харж ажиглахыг зорилго болгоод, түүнээс сэтгэлийн таашаал авч чаддаг хүмүүсийг ерөнхийд нь “шувуу ажиглагч” гэж үздэг. Тус аялал нь энгийн ба мэргэжлийн шувуу ажиглагч гэсэн хоёр хэлбэрийн оролцогчтой байдаг. Энгийн шувуу ажиглагч нь тухайн зүйл шувуудыг гүнзгийрүүлэн судалж хөөдөггүй, зөвхөн өөрийн харсан шувуудын тоог нэмэх, бүртгэлээ баяжуулах, байгалийн үзэсгэлэн, бусад ан амьтан, цэцэг ургамлаас давхар сэтгэлийн таашаал авч амрахыг хүссэн хүмүүс ихэвчлэн байдаг. Харин мэргэжлийн шувуу ажиглагч нь нарийн боловсруулсан маршрутын төлөвлөгөөтэй, харах шувуудын талаар нарийн мэдээлэлтэй, аль болох шинэ зүйл шувуудыг харах зорилготой, тухайн бүс нутгийн эндемик болон дэлхийн түвшинд ховордсон шувуудыг олж харахыг эрмэлзэж байдаг. Мэргэжлийн шувуу ажиглагчид шувуудын амьдралыг таньж мэдэхийн төлөө ихэнх чөлөөт цагаа зарцуулсан хүмүүс бөгөөд ямар нэгэн клуб, холбоо, аяллын багийн ахлагч нар байдаг.

Зорилго болгосон шувуу нь хаана байж болохыг мэргэжлийн судлаач нараас асууж зөвлөмж авах, судалгааны баримт, бүртгэлийн тоо баримтыг нягталсны үндсэн дээр тухайн аяллын хөтөлбөрийг боловсруулна. Шувуу ажиглах аялалд шувуу судлаач мэргэжлийн хөтөч зайлшгүй шаардлагатай. Шувуу ажиглалтын цэгийг тогтоох, өндөрлөг тавцанг дуран байрлуулж болохоор байгуулах, шувуу ажиглагч гадаад жуулчдад урт түрийтэй усны гутлууд, шумуулаас хамгаалах тор зэрэг хэрэгслүүд хэрэгтэй байдаг.

Сүхбаатар аймгийн ГАНГА, ХОЛБОО, ДУУТ, ХОШМОГ, ЭРДЭНЭ УУЛЫН НУУР-ын орчинд ус, эргийн шувууд ажиглах, МӨНХХААН УУЛСЫН САЛБАР УУЛС-аар хээрийн махчин шувуудыг ажиглах аяллын чиглэл төлөвлөж, Хэнтий, Дорнод аймгийн маршруттай хамтатган хэрэгжүүлэх боломжтой.



4.2 НҮҮДЭЛЧДИЙН СОЁЛТОЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлал (Үүнийг Монголын аялал жуулчлалын салбарт НИТАЖ гэж хэлдэг) хөгжүүлэх бүрэн боломжтой. Нутгийн иргэдийг аялал жуулчлалд татан оролцуулснаар гадаад, дотоодын жуулчдад Монголын нүүдэлчин амьдрал, ахуй соёлыг илүү мэдрүүлэх боломжтой. НИТАЖ-ын үйлчилгээг сонгосон гадаадын жуулчинд гэрийн орчин, хоол үйлчилгээ, нөхөрсөг байдал чухал бөгөөд жуулчны баазын үйлчилгээнээс илүү сэтгэл ханамжийг өгч чаддаг. НИТАЖ-ын айлуудад учирдаг бэрхшээл нь гэрийн орчин нөхцөлийг байнга бэлэн байлгахад хүндрэлтэй, хоолны нэр төрөл, үйлчилгээнд санаа зовох, гадаад хэлний мэдлэг дутах асуудал бий.

НИТАЖ-ын сүлжээний айл нь гадаад жуулчинг гэр бүлийн гишүүн мэт үзэж нөхөрсөгөөр харилцаж үйлчлэх нь жуулчид дахин Монголыг зорин ирэх, өөрийн аяллын тухай мэдээллийг ам дамжуулан түгээх нь аялал жуулчлалын өсөлтөнд зэрэг нөлөөтэй. Тансаг эд хэрэглээгээр бус “тансаг үйлчилгээ”-гээр жуулчдыг татах ёстой бөгөөд тухайн жуулчинд Монголоос өөр газарт авахааргүй онцгой сэтгэгдэл мэдрэмжийг төрүүлэх нь НИТАЖ-ын гол зорилго юм.

“Фермерийн аялал жуулчлал” 1970-аад оноос “Амьдар, суралц, байгальтай ойртсон амьдралын сайханыг амс” гэсэн уриатайгаар Их Британи улсад хөгжиж эхэлсэн. Эдүгээ дэлхийн 80 орны 6000 фермерийн аж ахуй аялал жуулчлалыг хөгжүүлж, WWFO (World Wide Opportunities on Organic Farms) холбоо хүртэл байгуулагдсан байдаг. Италийн Сицил, Сардини, Тоскана тосгонд жуулчид байгалийн сайхныг мэдрэхээс гадна итали хоол, үндэсний дарс хийж сурдаг. Францын фермүүдэд жуулчид дарс, бяслаг хийж, анд явж, загасчилж, морь унаж, үндэсний гар урлалд суралцдаг. Финландын фермд өвс хадах, мал хариулах, жимс тариалах, үнээ саах зэргээр өдөр тутмын аж амьдрал оролцдог. Монголд “фермерийн аялал жуулчлал”-ыг хөгжүүлэх боломж бий. Жил бүр зохион байгуулагддаг олон улсын фермерүүдийн үзэсгэлэнд оролцож өөрсдийгөө “монголын фермерүүд” гэж таниулах шаардлагатай.

Жуулчид ихэвчлэн хүүхэдтэйгээ, гэр бүлээрээ энэ аяллын төрлийг сонгож аялдаг. Учир нь хүүхдүүдээ интернет орчноос холдуулах, сэтгэлгээг нь задлах, өөрийгөө нээх, байгаль орчин, ан амьтан, өөр бусад соёл иргэншил, зан заншлыг мэдрүүлэх гэж аялдаг болсон судалгаа бий.



Монгол малчин айлын өдөр тутмын гэрийн ажилд оролцох, ойрын зайн морин аялал хийх, ойролцоох байгаль, түүх, соёлын газартай танилцах хагас өдөр, 1-2 өдрийн аяллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх боломжтой. Эл аялал жуулчлалаар монгол ёс заншлын бүхий л арга ажиллагааг сэргээж болно.

- Цагаан идээ бэлдэх, сүү хөөрүүлэх, өрөм загсаах, тараг бүрэх, архи нэрэх, ааруул хийх, бяслаг шахах, үндэсний хоол, унд хийх, сүүтэй цай чанах, боорцог хайрах, хуушуур хийх, бууз хийх, мах чанах, бантан хийх,
- Мал маллах арга ажиллагаа, мал хариулах, мал тооллого хийх, малыг бэлчээрээр маллахын ач холбогдлыг таниулах, ноослох, малын хашаа хороо бэлдэх, мал усалгаа, хаваржаа, намаржаа руу нүүх, буурь сэлгэх,
- Халх, үзэмчин, дарьганга соёл, уламжлал, гэр барих, дээл эсгэх, нэмнээ элгэвч, төлийн үүт оёх,
- Мод түлээ бэлдэх, аргал түүх, арьс элдэх, ундны усанд явах, шагайгаар наадах,
- Адууны өв соёл танилцуулах, адуу хураах, уургалах, эмнэг булгиулах, гүү саах, айраг исгэх, эмээлийн мод хийх, адууны ногт хэрэгсэл хийх, хурдан адуу шинжих, уяа сойлго хийх, унага тамгалах, адуу манах,
- Урлаг соёлын өв буюу ардын дуу сурах, морин хуур тоглох, дэмбээдэх, хуруудах... гэх мэт өв соёл, зан заншлыг таниулах, сурталчлах, заримыг нь зааж сургах боломжтой.



НИТАЖ-ын сүлжээний өрхийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн жишиг

НЭМҮҮ ӨРТӨГ ШИНГЭСЭН БҮТЭЭГДЭХҮҮН:

Монгол Улсын Засгийн газар, ДАЖБ-аас “нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн” үйлдвэрлэлийг дэмжих, нэмүү өртөгийн сүлжээнд өрсөлдөх чадварыг сайжруулах бодлого баримталж байна. Улмаар нэмүү өртөгийн сүлжээнд малчин өрхүүдийг хамруулж, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг өртөг нэмэгдүүлсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгох боломж байгааг тодорхойлж байна. Аялал жуулчлалын өртөгийн сүлжээний бүх шат дамжлагад бүтээгдэхүүн үйлчилгээний өртөгийг өсгөх боломжтой. Өртөг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн гэдэг нь ЧАНАР ба ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭ ЦЭНЭ бүхий үйл ажиллагааны шат дамжлага бүрийн төгсгөлд нэмэгдэх зөрүү юм.



№	Бүтээгдэхүүн үйлчилгээ	Тэрэлжийн малчин өрх	Өмнөговь аймгийн малчин өрх	Сүхбаатар аймгийн малчин өрх
1	Хонуулах үйлчилгээ / 1 ор	15,000	20,000	15,000
2	Хоол хийх /1 удаа	12,000	10,000	8,000
3	Малчин айлд зочлох /1жуулчин	10,000	10,000	10,000
4	Хорхог хийх /ямаа	200,000	200,000	200,000
5	Хорхог хийх /хонь	250,000	250,000	250,000
6	Морь унуулах /цагаар	15,000	20,000	10,000
7	Морь унуулах /өдрөөр	40,000	60,000	30,000
8	Морины хөтөч /цагаар	15,000	15,000	10,000
9	Морины хөтөч /өдрөөр	40,000	50,000	30,000
10	Тэмээ унуулах /цагаар	30,000	15,000	=
11	Тэмээ унуулах /өдрөөр	=	60,000	=
12	Орон нутгийн хөтөч /өдрөөр	50,000	50,000	30,000
13	Машин түрээс –жийп/өдрөөр	150,000	150,000	120,000
14	Машин түрээс – жижиг/өдрөөр	60,000	=	=
15	Ердийн хөсгөөр нүүдэл хийх	150,000	150,000	=
16	Өрхийн тоглолт- 20мин/1 жуулчин	20,000	20,000	=
17	Морин чарга /цагаар	25,000	=	=
18	Нохойн чарга /цагаар	35,000	=	=
19	Дээл хийх, материал орсон /1 жуулчинд	200,000	=	=

Тухайлбал,

- Нэг өрх айл 4 ортой гэр буудал ажиллуулдаг байлаа гэхэд үнэ нь бусад айлын ажиллуулдаг гэр буудлаас 5000 – 10000 төгрөгөөр илүү байж болно. Илүү үнэтэй байх нөхцөл нь юу вэ гэхээр тухайн гэр буудалд өлгүүр, угаалтуур, шингэн саван, халбага сэрээ, таваг, аяга, ус буцалгагч, шүдний чигчлүүр, гэрийн шаахай, телевиз хүртэл тавьж тохижуулсан явдал юм. Цагаан хэрэглэл нь чанартай даавуу байвал үйлчлүүлэгчид сэтгэл хангалуун болно. Үүнийг “өртөг нэмэгдүүлсэн үйлчилгээ буюу бүтээгдэхүүн” гэж ойлгож болно.

- Ангын зөвшөөрлөөр гахай агналаа гэхэд махыг нь дотоодын аялагчдад түүхийгээр нь борлуулах нэг хэрэг. Харин түүнийг утах, шарах гэх мэтээр боловсруулж ямар нэгэн тансаг хоол болгон борлуулснаар “өртөг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн” болно.

Монголд малчдын нөхөрлөл, иргэдийн нөхөрлөл хэмээх бүлгүүд “эко гэр бааз” ажиллуулж ихэвчлэн ганцаарчилсан үүргэвчтэй жуулчдыг хүлээн авдаг.

Хэдийгээр “эко гэр” гэж нэрлэдэг ч эко гэсэн утгыг төлөөлөх ямар нэгэн онцлог зүйлс байдаггүй. Зөвхөн хонуулах, морь, тэмээ унуулахаас өөр үйлчилгээ байдаггүй дутагдалтай.

Сүхбаатар аймгийн ГАЗАР ШАВАР ЗУУХ нь өөр аймагт байдаггүй өвөрмөц зүйл учраас дотоодын жуулчид, гэр бүлээрээ аялан яваа хүмүүст зориулан өөрсдөө хоол, цайгаа бэлдэж хийх боломжтой “газар шавар зуух”-тай ГЭР БУУДАЛ ажиллуулж онцлог “брэнд” үүсгэж болно. Аялагч жуулчдын ярианы сэдвийг нэмэгдүүлсэн “сурталчилгаа” болох юм.

ЗӨВЛӨМЖ:

- Малчин айл өөрсдийгөө бэлдэх, амьдралын орчин нөхцөлөө өөрчлөхөд бэлэн байх
- Идэвх санаачилгатай байж ахмад үеэсээ асууж сураглаж мартагдсан ёс заншил, өв соёлыг сэргээх
- Шинээр мэдсэн сурсан соёлын өвийн мэдлэгээ бичиж тэмдэглэж, үр хүүхэддээ уламжлуулах
- Үйл ажиллагаа тогтмолжиж, байнгын орлоготой болох хүртэл үйгагүй хөдөлмөр хэрэгтэй ба сэтгэл санааны бэлтгэлтэй байх, зорилгоо санаж байх
- Аялал жуулчлалаас олох орлого, өрхийн бүтээгдэхүүнийг тогтоох, интернет орчинд таниулан сурталчилах
- Уламжлалт хоол ундны цэстэй байх
- Уламжлалт тоглоом наадгайг сайтар сэргээн эзэмших, жуулчдад заах аргачлалтай байх
- Жуулчинд унуулах морь, ердийн хөсөгний малыг бэлдэж сургах
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх мэдлэг, чадвартай байх





ОРОН НУТАГ ДАХЬ СУДАЛГААГААР ИЛЭРСЭН ДУТАГДАЛ:

Хустайн нуруу, Горхи-Тэрэлж дэх малчин айл, нөхөрлөл, эко гэрүүдэд хонож үйлчлүүлсэн гадаад жуулчдын сэтгэгдлээс түүвэрлэснийг сийрүүлэв.

Сэдэв	Нөхцөл байдал ямар байв?
Ариун цэвэр, эрүүл ахуй	<ul style="list-style-type: none"> • Биеэ хөнгөн угаах боломж байхгүй • Угаасан аяга тавагнаас өөх тос үнэртдэг • Нэг алчуураар бүх зүйлийг цэвэрлэдэг • Жорлон бохир, үнэртэй • Жорлонгийн цаас байхгүй • Орчин тойрон гадуураа хог хаягдал ихтэй
Хоол	<ul style="list-style-type: none"> • Өглөөний хоолонд халуун хоол хийж өгдөг • Боорцог хатсан, хөгц үнэртсэн байдалтай • Өдөр бүр нэг төрлийн хоол өгдөг • Хоол өөх ихтэй • Дотор гэдсээр хийсэн хоолонд хүн бүр дуртай байдаггүй • Жуулчид хоолны үнийг мэддэггүй
Тохь тухтай байдал	<ul style="list-style-type: none"> • Орон дээр унтахад хатуу/банзтай ор/ • Хувцсаа өлгөх газар олддоггүй • Хаалга тогшилгүй орж ирдэг • Гэрийн гадна суух газар олддоггүй • Гэрт өглөө үүрээр хүйтэн байдаг, гал түлж өгдөггүй
Аюулгүй байдал	<ul style="list-style-type: none"> • Морь, тэмээ унуулах, аюулгүй байдлын зөвлөмж дутуу өгдөг • Зарим нохой нь зуудаг • Хулгай гардаг
Орчны соёл, харилцаа	<ul style="list-style-type: none"> • Нутгийн хүмүүс хэт орчин үеийн болж өөрчлөгдсөн • Үйлчилгээний соёлын мэдлэг байхгүй • Архи уух байдал, согтуу хүмүүс жуулчдыг маш их түгшээдэг • Хөтөч нар орон нутгийнхаа талаар мэддэггүй • Хотоос ирсэн хөтөч орон нутгийн талаар мэддэггүй • Дотоод аялагчдын байгаль орчинтойгоо харьцах үхамсар муу

4.3 МОРИН АЯЛАЛ

Монголын байгаль, монгол хүн, тэдний нөхөр болсон агт морьдын хоорондох амьд харилцааг морин аяллаар мэдрүүлэх боломжтой. Морь унах нь хүний биеийн булчинг жигд ажиллуулдаг. Монголд “Жуулчинд үйлчлэх товчоо” байгуулагдсан тэр цаг үеэс гадаад жуулчдад морь унуулах үйлчилгээ эхэлсэн түүхтэй.




Аялал явагддаг бүс	Аялал үргэлжлэх хугацаа	Морин аяллын жуулчид
<ul style="list-style-type: none"> • Тэрэлжид 33% • Хөвсгөлд 27% • Өвөрхангайд 20% • Архангайд 11% • Хэнтийд 5% 	<ul style="list-style-type: none"> • 58% нь 5-7 хоног • 21% нь 8-10 хоног • 15% нь 12-14 хоног 	<ul style="list-style-type: none"> • Солонгос 32.5% • Япон 18% • Герман 15% • Швейцарь 9% • Франц 8.5% • Голланд 8% • Америк 7%

Морин аяллын зорилго нь байгаль харах, малчин айлд зочлох, нүүдлийн соёлыг биеэр мэдрэх, түүх соёлын дурсгалт газруудыг үзэхэд оршдог. Монголын тур оператор компаниуд өдөрт 20-30км зай туулахаар 5-21 хүртэл хоногийн морин аяллын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Олон хоногийн морин аяллыг замдаа 3-4 айлын морь сэлгэж, машин дагалдуулах ба дагалдуулахгүй хэлбэрээр төлөвлөдөг. Машин дагалдахгүй аялалд бүх ачаа тээш, хоол хүнсээ ачааны морьдод ачиж явдаг. Морин аялал нь бүхэлдээ маш том хариуцлага, сахилгын асуудал бөгөөд жуулчны амь нас, бүрэн бүтэн байдал нь зохион байгуулж буй аяллын компани, аяллын хөтөч, морины хөтөч, сургасан морьдоос хамаарна. Морин аяллын компани нь өөрийн жуулчны баазыг түшиглэсэн адуун сүрэг, адуучинтай байх ба морины тоног хэрэгсэл, жуулчинд хамаарах хэрэгсэл зэргийг хангасан байдаг. Сүхбаатар аймагт холын ба ойрын зайн морин аяллын маршрут төлөвлөж хэрэгжүүлэх боломжтой.

ЗӨВЛӨМЖ:

- Морины хөтчийг 2-3 жуулчинд нэг оногдохоор төлөвлөж, жуулчинд тохирсон эмээл ба гутал, хамгаалалтын малгай, хөлийн шилбэ болон гарын шууны хамгаалалт зэргийг бэлдэнэ. Жуулчинд аюулгүй байдлын зааварчилга өгч зарим тохиолдолд хариуцлагын гэрээ байгуулах.
- Морины хөтчийн биеэ авч явах ёсзүй, хувийн ариун цэврийн асуудалд анхаарах хэрэгтэй байдаг.
- Жуулчны аюулгүй байдлыг хангахын тулд морь үргэхээс сэргийлэх чухал бөгөөд мордох, жолоодох, залах, хөтлөхийг жуулчинд нарийн заах. Үргэдэг, цочдог, хазаж хажигладаг, авч давхидаг, номхон, догшин гэх мэт морины зан аашийг хүртэл жуулчинд сануулах, анхааруулах, хэрхэн харьцахыг зааж өгнө.
- Ой модон дотор явах, ус гол гатлах, мориноос буух, шонгоос уяхад анхаарах зүйлсийг жуулчинд нэгбүрчлэн сануулах.

МОРИН АЯЛЛЫН МАРШРУТ



4.4 СОЁЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэг томоохон бүрдэл хэсэг нь үзэх үзмэр буюу соёлын өв, эвент арга хэмжээний хөтөлбөрүүд юм. Соёлын өв нь цаг үеийн шалгуурыг давсан, бүх нийтийн хүлээн зөвшөөрсөн, тухайн ард түмний оршин тогтнох үндэс болсон түүх, соёл, угсаатан, шинжлэх ухаан, урлагийн ач холбогдолтой биет болон биет бус үнэт зүйл. “Соёлын аялал жуулчлал” гэдэг нь зочин-жуулчин тухайн бүс орон нутгийн соёлыг хэрэглэх, мэдрэх, хүлээн авах үйл ажиллагаа юм.

Биет өв: 2015 онд “Түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллого”-оор улсын хэмжээнд 9537 дурсгалт газрын 86157 ширхэг үл хөдлөх дурсгал бүртгэгдсэн. Биет өв нь суурин газраас хол зайд байрлах, алдагдах, тоногдох, эзэнгүйдэх, сэргээн засварлалт шаардлагатай болох, буруу хадгалалтын орчин нөхцөл үүсэх, нутгийн иргэдийн “өмчилсөн” эзэмшилд орох зэрэг эрсдэлтэй учирдаг. Биет өвийг аялал жуулчлалаар дамжуулан таниулах, хөрөнгө оруулагчдын анхааралд оруулах, орон нутгийн захиргааны эрх үүрэг оролцоог нэмэгдүүлэн хадгалж хамгаалах, болзошгүй эрсдэл гэмтлээс сэргийлэх боломж бүрддэг.

Биет бус өв: Соёлын биет бус өвд тууль, ерөөл магтаал гэх мэт аман уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэрүүд, уртын дуу, хөөмэй, бий биелэг гэх мэт урлагийн тоглолт үзүүлбэрүүд, уран дархан, сийлбэр гэх мэт урлал, даахь үргээх, унага тамгалах гэх мэт зан үйл, Ёохор, Баргажин, Алтаргана наадам гэх мэт соёлын эвент, айраг эсгэх, архи нэрэх, дээл эсгэх гэх мэт зан заншил, бүргэдийн ан, анч нохой сургах гэх мэт байгаль болон сав ертөнцийн тухай мэдлэг, оёдол хатгамал, зээгт наамал, ширдэг ширэх гэх мэт уламжлалт гар урлал зэргийг соёлын биет бус өвд багтаан авч үздэг.

Сүхбаатар аймгийн **“Агтана хүрээт”, “Хатагины наадам”, “Нарах харах аялал”, “Алтан-Овооны тахилга”** гэх мэт тогтмолжсон эвент хөтөлбөрүүдийг улам чанаржуулан хөгжүүлж дотоод, гадаадын жуулчдыг татах менежмент хэрэгжүүлэх боломжтой. Соёлын аялал жуулчлалаар дамжуулан Сүхбаатар аймгийн биет бус өв тээгчдийг сурталчлан таниулах, залуу үед өвлүүлэн үлдээх, дарьганга, үзэмчин угсаатны соёл, зан заншлыг сэргээн хөгжүүлж таниулах гэх мэт чухал ач холбогдолтой.



I ХАТАГИНЫ НААДАМ:

Хатагины наадам нь анх Дорнод аймгийн Матад суманд 2009.09.09-ний өдөр зохион байгуулагдаж байсан. Харин II наадам 2012 онд Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд, III наадам 2015 онд Дарханхаан буюу Сүхбаатар суманд, IV наадам 2018 онд Матад суманд гэх мэтээр 3 жил тутамд зохион байгуулагдсаар ирсэн.

Хуучнаар Хурц вангийн хошуу, Ёст бэйсийн хошуу, Үйзэн вангийн хошуу буюу одоогийн Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар сум, Дорнод аймгийн Матад сумынхан “хатагин” овогтнууд юм. Анх хатагин овогт Егүзэр хутагт гарч ирж хатагинчуудаа таниулсныг түүхийн хуудас өгүүлдэг. Мөн их бичгийн эрдэмтэн “Хатагин овгийн нүүдэлчин, харц язгуурт Ц.Дамдинсүрэн” гэж өөрийгөө таниулсан. Монголын оюун ухааны түүхэнд ихээхэн үнэтэй хувь нэмэр оруулсан олон хамба хутагтууд, эрдэмтэн мэргэд хатагин овогтон байсан.

Наадмын хүрээнд ЭШХ, урлаг спортын баяр, яруу найргийн наадам, Хатагины хар сүлдийг цэнгүүлэх ёслол, эрийн гурван наадам болдог. Эрдэнэцагаан сумын яруу найрагч Н.Лутбаяр нь Хатагины хар түгийг авч явсан зайсангийн үр удам бөгөөд тэднийд хатагины хар сүлдний сэрээ нь хадгалагдаж байжээ. Гилбэрийг нь урлуулаад гурван сумынхаа хар азарганы хөхлийн хялгасаар бүрдүүлж “амь оруулсан”. Эл өв соёлыг Өвөрмонголын Үүшүн хошуунаас тугч ирж гүйцэлдүүлэн ёслол үйлдсэн.

Хатагин овогтны өвөг дээдэс бол “Буха Хатаги” юм. МНТ-нд өгүүлснээр Алунгоо эхийн хэвлийгээс тэнгэрээс буусан шар гэрлийн тэмдэгээр Буха Хатаги, Бухад салжу, Боданчар мунхаг төрдөг. Тэд нар тэнгэрээс заяат гурван хөвүүн болж, монголчууд тэнгэр язгууртай болсон. Энэ гурваас салжууд овог нь үлдсэнгүй, харин боржигон ба хатагин овог үлдсэн. Өвөрмонголын Алшаа аймаг, Оросын Буриадад ч хатагинчууд бий. Одоогийн Өвөрхангайд байсан хатагинчууд Галдан бошигтын үймээний үед дүрвэж Буриад руу гарсан байдаг. Алшаа аймгийн Үүшүн хошууныхан уламжлалаа хадгалж туг сүлдээ нууцлан хадгалж ирснийг эрдэмтдийн эх сурвалжаас мэджээ. Эдүгээ Хатагины уул бүгд орой дээрээ 13 овоотой байдаг онцлогтой.



Алтан овооны тахилга



ТАВ. АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН МАРКЕТИНГ, МЕНЕЖМЕНТ

5.1 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР ОЛГОЛТ

Аймаг, сумдын ЗД, ИХТ нар аялал жуулчлалын зориулалтаар газрын зөвшөөрөл олгохдоо дараах зөвлөмжийг анхааран үзэхийг сануулж байна. Газар эзэмших зөвшөөрлийн гэрчилгээг олгохдоо МУ-ын газрын тухай хуулийн дагуу ажиллана. Мөн хуульд заасан нөхцөл, зүйл заалтуудыг тайлбарласан Дээд шүүхийн тогтоол, Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам, Газрын төлбөрийн тухай хууль зэргийг анхаарах нь зүйтэй. Монгол орны яг юуг үзэхээр аялагчид зорьж ирдэгийг ойлгож, жуулчдад үйлчилдэг бизнесийг дампууруулахгүй байх, жуулчдыг олноор тогтвортой татах, байгалийн өвөрмөц тогтоц, онцлог байдал, амьтан ургамлын сангаа ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх эрмэлзэл агуулан ажиллах хэрэгтэй. Аялал жуулчлалын хяналтгүй үйл ажиллагаа нь тухайн бүс нутгийн зэрлэг ан амьтан, ургамлын сан, малын бэлчээр, усан сан, онгон дагшин байдалд шууд болон шууд бусаар сөрөг нөлөө үзүүлдэг тул тэдгээрээс урьдчилан сэргийлэх, мүү нөлөөллийг аль болох багасгах зэрэгт засаг дарга хүний оруулах бодит хувь нэмэр бол газар эзэмших зөвшөөрлийн гэрчилгээг зөв зохистой төлөвлөлттэйгөөр олгох явдал юм. Газар олгохдоо өөрийгөө аялагч гэж сэтгэх хэрэгтэй.

Нэг. Үзэгдэх орчин 360° байх.

Эргэн тойронд байгаль тэр чигээрээ алаглаж байвал цэвэр 360° үзэгдэх орчинтой гэсэн үг. Үзэгдэх орчинд Монголыг тодотгох бэлчиж буй үхэр, хонин сүрэг, морь тэмээгээ унасан малчин, өвөлжөө, хаваржаа, монгол гэр гэх мэт дүр төрх харагдаж байвал гадаад жуулчинд ер бусын мэдрэмж таашаал өгнө. Үзэгдэх орчныг хамгийн зөв төлөвлөсөн шилдэг газар бол Даланзадгадаас баруун хойш 70 км зайд орших “Говийн гурван тэмээ” бааз юм. Жил бүр дэлхийн шилдэг 50 эко лоожид нэрлэгдэж шалгардаг. Тус баазын орчинд өөр ямар ч бааз байхгүй, уулын энгэрийг түшиглэж байгуулсан, өмнө талд нь тэр чигээрээ ховсдон татах хөндий тал үргэлжилдэг. Хамгийн мүү жишээ бол Хөвсгөл нуурын эргийг шавсан баазуудын газар олголт, мөн Цонжинболдогийн Чингисийн морьт хөшөөний орчин дахь замбараагүй газар олголт юм. Гадаадын жуулчид гэр хороолол мэт хөглөрсөн, газар нь эвдэгдэж олон салаа зам үүссэн талхагдлыг харах гэж Монголд ирдэггүй.

Хоёр. Дуу хүрэхгүй орчин чухал.

Жуулчны баазууд харилцан бие биедээ дуу хүрэхгүй орчинд байрлах нь чухал. Дотоодын аялагчид ихээр буудаг баазын хувьд нас насныханд тохирсон зохион байгуулалт хуваарилалтыг хийхгүй бол нам гүм, чимээгүй орчинд дурлаж ирсэн гадаад жуулчдад тэдний дуу чимээ их саад болдог. Мөн ахмад настнууд хүүхэд залуучуудын шуугианд тав тухгүй байх нь бий. Караокэ байгуулахаар бол амрагчдын гэр, өрөө тасалгаанд сонсогдохооргүй байх ёстой. Мөн чимээ шуугиан нь ойр орчны ан амьтан, ховор шувуудыг үргээх зэргээр биологийн болон байгалийн нөөцөд сөргөөр нөлөөлдөг тул эко системийг эвдэхгүй байхыг эрмэлзэх хэрэгтэй.

Гурав. Гол үзмэр үзүүллэгээс өдрийн аяллын зайд газар олгох.

Зочин хонуулах баазууд нь томоохон хөрөнгө оруулалт шаарддаг бөгөөд тэр том хөрөнгө оруулагчид хаана газар олгох вэ гэдгийг сайтар тунгаах хэрэгтэй. Нутгийнхаа хамгийн их хүн ирж үздэг гол үзмэрийнхээ дэргэд газар өгчихвөл тухайн баазад хонож өнжин саатах бус зогсоол дээр нь машинаа тавьж, үзмэрээ үзчихээд яваад өгнө. Нөгөө талаар орон нутгийнханд ч үр өгөөжөө өгөхгүй. Хөрөнгө оруулж бааз барих хүнд сумынхаа гол зорин очих газраас 5-20 км зайд газар олгох нь зөв болно. Баазаас тухайн газар руу 5 км газарт мориор аялж очсоноор нэг өдөр саатаж дахиад нэг хонох, мөн тухайн орчны малчин айлын морийг эргэлтэнд оруулах зэрэг ач холбогдолтой. Энэ тал дээр хамгийн муу жишээ бол Өгий нуур юм. Олон баазууд яг нуурын эрэг дээрээ тулж байрлаад хол ойрын хүн болгон тэнд бууж орчны хог хаягдал ихсэж, загас нь багасаж, монголчуудын шорлог хийдэг хар зах шиг болж хувирсан. Хэдэн жилийн өмнө Өгий нуурын баазад гадаад жуулчид хонох дуртай байсан бол одоо өдрийн хоол идчихээд хонохгүйгээр шүүд яваад өгдөг, өөрөөр хэлбэл “дайран өнгөрдөг” орлого үлдээдэггүй газар болсон юм.

Эртний хот, суурингийн балгас, туурь, сүм хийд, дуган, шашны зан үйлийн газрын ойр орчимд газар олгохдоо тэдгээрийн зах хаяанд бус хол зайтай байгуулах, байшин барилгыг монгол үндэсний хэв маягтай, эсвэл сүм дуганы орой мэт дээвэртэй байх зэрэг хэлбэр загварыг санал болгож дэмжих нь зөв болно. Хүн чулуу, чулуун дурсгал, буган хөшөө зэрэг нь ихэвчлэн тал хөндийд тааралдах бөгөөд тэдгээрийн үзэгдэх орчинд байшин барилга баривал нөлөөнд нь автан үнэ цэнээ алдах тул багаар бодоход 5 км-ээс дээш зайд газар олгоход анхаарах хэрэгтэй. БЦГ-т жуулчны бааз байгуулахад газрын зөвшөөрөл олгож болдог, харин ДЦГ-т байршуулах хэрэгсэлд газар олгодоггүй хуультай.

Дөрөв. Эко бүсийн онцлогт тохируулан газар олгох.

Ойт хээрийн бүсэд зэрлэг ан амьтдын тайван байдлыг алдагдуулахгүй байх, ойн гүн рүү амьтад дайжиж зугтах, ан амьтад бэлчээр сэлгэхэд хүрч тухайн нутгаас явах, ойн өвсөн бүрхүүл гэмтэж байхгүй болох зэрэг хүний сөрөг нөлөөллөөс хамгаалж ойн захаас 100-500м зайтай газарт зөвшөөрөл олгох хэрэгтэй. Хэрвээ өдөр бүр 50 хүртэл хүн ойн жимээр алхаад байвал өвсөн бүрхүүл нь 7 хоногийн дараа алга болдог. Ойн бүсэд байгуулж буй жуулчны баазын хөтөлбөрт диско бүжиг, караоке дуулах зэрэг хөтөлбөрийг зөвшөөрөхгүй байх хэрэгтэй. Хэт их дуу чимээ нь тухайн бүс нутгийг ан амьтан, шувуудын жиргээгүй болгох эрсдэлтэй.

Усны ундарга, булаг, гол горхи, рашааны эхийг бохирдохоос сэргийлж дор хаяж 500 - 1000м зайд газар олгох, үйл ажиллагаа явуулах байр байгууламжийг аль болох байгалийн мод, чулуугаар хийх, жуулчдын явган зам, жижиг хашлага зэргийг унасан мод ашиглаж хийх, сонирхол татахуйц хэв загвараар байгуулахыг дэмжих. Байшин барилгыг хоёр давхараас илүүгүй байлгаж хүрээлэн буй орчинд уусан зохицох өнгө будагтай байлгахыг шаардах хэрэгтэй. Эсгий гэрээр бааз, ресорт барихыг илүүтэй дэмжиж, хог хаягдал, ариун цэврийн өрөөний стандарт хангах шаардлага тавих нь чухал.

Хээрийн бүсэд газар олгохдоо нутгийн иргэдийн мал ундаалах чухал гол горхи, худаг устай давхцахгүй газарт зөвшөөрөл олгох. Барилга байгууламжийн загвар дизайн нь тал нутаг, уулс хоорондын хотгор гүдгэр, хөндий хоолойд зохицож ууссан байх, орчин үеийн шил толин барилгаас татгалзах, нутгийн нүүдлийн соёл иргэншилтэй уялдуулан хөгжүүлэхийг дэмжих хэрэгтэй. Мөн тухайн бааз руу тал талаас шинэ зам үүсгэн очихгүй байхыг анхаарч замын тэмдэг тэмдэглэгээг гол зам дагуулан босгож хөрсний эвдрэл үүсгэхээс зайлсхийх нь чухал.

5.2 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУРТАЛЧИЛГАА

Судалгаанаас үзэхэд аялалдаа сэтгэл ханамж аваагүй нэг жуулчин цааш нь 100 хүнд энэ тухайгаа ярьж хуваалцдаг байхад сэтгэл ханамжтай байсан нэг жуулчин цааш нь 36 хүнд ярьж сурталчилдаг. Нийгмийн сүлжээгээр “тайлан” тавьдаг болсон өнөө үед жуулчны сэтгэл ханамж чухал нөлөө үзүүлэх учраас үйлчилгээний чанар, мэргэжлийн ур чадварыг хариуцлагатай өндөр түвшинд байлгах шаардлага тулгарч байна. ДАЖБ-ын 2018 оны судалгаагаар дэлхийд 5 хүний 4 нь бүс нутагтаа аялдаг хэмээн тогтоосон. Онгон дагшин байгаль, нүүдлийн соёл иргэншил, хүн хөшөөдийн домог түүх, Алтан-Овоо, Шилийн богд, Зотол хан, Талын агуй гэх мэт газруудыг **“Main story line”** болгож баяжуулан хөгжүүлэх нь Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын зорилго юм.

Цахим хуудас (Website)-ны сурталчилгаа:

- Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын цахим хуудастай байх. Аяллын маршрут, эвент, соёлын арга хэмжээг цахим хуудсанд байршуулж, тогтмол идэвхжүүлэх, англи хэлний хувилбартай байлгах
- Өөр бусад аялал жуулчлалын нэгдсэн цахим хуудас, захиалгын системтэй холбох
- Сүхбаатар аймгийн сурталчилгааны дүрс бичлэгийг мэргэжлийн түвшинд хийлгэж байршуулах
- Хятад хэлтэй зах зээлд зориулсан QR Code болон WeChat-ийг нэвтрүүлэх

Товхимол хэлбэрийн сурталчилгаа:

- Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын газрын зургийг тогтмол шинэчлэн хэвлэж борлуулалтанд байлгах
- Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын гарын авлага болох “Guide book” хэвлүүлж худалдаанд гаргах

ТВ, FM сурталчилгаа:

- Соёл урлаг, танин мэдэхүйн нэвтрүүлэг, эвент арга хэмжээгээр дамжуулан сурталчлах
- Үндэсний үйлдвэрлэгч томоохон компаниудын маркетинг сурталчилгаанд түншлэл тогтоож шилдэгүүд, азтангуудыг Сүхбаатар аймагт аялах эрхээр урамшуулах, аяллыг сурвалжлагаар баяжуулан дараагийн сурталчилгаанд ашиглах

Үзэсгэлэн яармаг, нээлттэй өдөрлөг:

- Монголын ITM үзэсгэлэнд тогтмол оролцох, түншилж оролцох
- ӨМӨЗО, Зүүн хойд Азийн орнууд, Хэнтий, Дорнод аймгийн үзэсгэлэн яармагт оролцох, илтгэл танилцуулга хийх
- Их Түмэн гол төсөл, Торгоны зам, Цайны зам төслүүдэд холбогдож сурталчлах
- Олон улсын тусгай сонирхлын нийгэмлэг, холбоо, клубуудад гишүүнээр элсэх

FAM TOUR сурталчилгаа:

- Мэргэжлийн түр оператор компаниудад зориулсан Сүхбаатар аймгийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг танилцуулах FAM TOUR буюу танилцах аялал зохион байгуулах



ДИЖИТАЛ СУРТАЛЧИЛГАА:

Аялал жуулчлалын салбарын интернет маркетинг нь тухайн бүтээгдэхүүний бодит дүрслэлийг интернетээр дамжуулан хэрэглэгчдэд харуулах замаар тэдэнтэй холбогдоход тусалдаг. Бүтээгдэхүүн үйлчилгээг таниулахын тулд төлбөртэй болон энгийн аргын аль алиныг нь ашиглах хэрэгтэй. Дижитал маркетингийн орчин үеийн технологи бол захиалгын систем юм.

Гэрэл зураг: Жуулчдын нүдэнд бодит дүрслэлийг бий болгож, онлайн ертөнцөд өөрийн биеэр оролцоход тусалдаг. Гэрэл зурагт тайлбар бичих болон tag (таг) хийхдээ түлхүүр үг ашиглах нь хайлтын системийн гэрэл зургийн илэрц дээр гарч ирэхэд чухал үүрэгтэй. Гэрэл зурагчидтай хамтарч ажиллан тухайн газрын хосгүй, өвөрмөц онцлогийг мэдрүүлж чадахуйц зураг бүтээхэд анхаарах. Олон нийт ихээр ашигладаг Фэйсбүүк болон Фликр дээр байршуулснаар хурдан түгдэг.

Видео бичлэг: Хэрэглэгчдэд үнэ цэнэтэй мэдээллийг өгөхөд видео бичлэг чухал үүрэгтэй. Жуулчин болон үйлчилгээ үзүүлэгч нар өөрсдөө бодитоор оролцож буй агшин үйл явдлыг видео бичлэг хэлбэрээр хүргэх нь илүү ач холбогдолтой. Жуулчны сэтгэл ханамж, сэтгэл хөдлөл, үг яриа зэрэг нь бусдад нөлөөлж урин дуудах, бусдыг татах зэргээр бүтээгдэхүүн үйлчилгээний борлуултанд эерэгээр нөлөөлдөг. Интернетэд байршуулахдаа хэмжээ, хайлтын түлхүүр үгийг анхаарах.

Онлайн бизнесийн шугам: Google maps (Гүүгл газрын зураг), Yahoo Business listings (Яахоо Бизнес шугам) үүнийг хүмүүс ихэвчлэн анзааралгүй орхидог. Гүүгл газрын зураг, Яахоо бизнес жагсаалтад бизнесийг бүртгүүлснээр тухайн аялалд хамаарах үгээр хайлт хийхэд илэрц дээр хамгийн эхэнд гарч ирэх боломжтой. Эдгээр шугам нь бүртгүүлэхэд үнэ төлбөргүй.

Блог болон нийтлэлүүд: Хүмүүсийн анхаарлыг татдаг мэргэжлийн түвшний мэдээлэл. Аяллын бүтээгдэхүүн үйлчилгээгээ шууд сурталчилсан нийтлэл бичиж болохгүй. Харин анхаарал татсан гарчиг, бүтээгдэхүүнтэй холбоотой сэдвээр уншигчдыг залхаахгүй мэдээллийг бэлтгэх нь үр дүнтэй.

Олон нийтийн сүлжээ: Facebook, Twitter, Instagram ... Нүүр ном, жиргээ, инстаграм зэрэгт нийтлэл, гэрэл зураг, видео бичлэгүүдийг байршуулах. Сонирхолтой мэдээллүүд оруулж байх нь дараа дараагийн мэдээллүүдийг сонирхон уншдаг дагагч дэмжигчдийг нэмэгдүүлэхэд нөлөөлдөг. Олон уншигчтай байх тусам олон хүнд хүрнэ.

Хүчирхэг Wi-Fi орчин: Хүчирхэг wi-fi орчинг зочид буудал, кофе кафенууд бий болгон өрсөлдөж байна. Жуулчид аялаар ирсэн газрынхаа орчинд зураг авч, бичлэг хийж өөрийн хуудсаар шууд сурталчилгаа хийх нь их байдаг. Тухайн газрын байгалийн үзэсгэлэн, сайхан үйл явдал, онцлогийг хайж эрэлхийлж таалагдсан бүхнийг шууд Wi-Fi ашиглан нийгмийн сүлжээнд цацдаг нь том сурталчилгаа болдог талтай.



Airbnb, Neighborhood Guides, Intercontinental Group, Hotel Indigo: Хүчтэй өрсөлдөгч нар буюу томоохон онлайн хөтөч, захиалгын сүлжээнүүд юм. Эдгээр нь газрын зураглал, тухайн газрын үзэж харах зүйлс, ресторан, зочид буудлын үнэлгээ зэрэг бүх мэдээллийг жуулчдад өгч чаддаг. Монголын Joinme.mn, ihotel.mn, tapatrip зэрэгт эхлээд холбох.

E-mail маркетинг: Нүүр ном болон жиргээний дагагчдын и-мэйл хаягуудыг цуглуулж сан үүсгэж аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаа, түсгай саналуудынхаа талаарх мэдээллийг 7 хоног эсвэл сард нэг удаа илгээж байх.

Website: Аливаа байгууллагын тухай интернет номын сан гэсэн үг. Тухайн байгууллагын намтар түүх, үйл ажиллагааг илэрхийлсэн албан ёсны талбар юм. Цахим хуудсаа гар утсанд зориулагдсан хувилбар бүтэцтэй байхаар шийдэх.

ДҮРС БИЧЛЭГ: Хүний уураг тархи текстэн мэдээллээс илүү дүрс бичлэг бүхий мэдээллийг 60000 дахин хурдан боловсруулах чадвартай байдаг ажээ. Видео бичлэг нь нийтлэл, блогуудаас илүү анхаарал татдаг. Хүмүүсийн 75% нь бичлэгийг үзэж дуусгадаг ба энэ нь текстэн мэдээллийг уншиж дуусгадаг хүмүүсийн хувьтай харьцуулахад маш өндөр үзүүлэлт юм. 2021 он гэхэд видео бичлэгүүд нь интернетийн урсгалын 85%-ийг бүрдүүлнэ хэмээн судлаачид үзсэн. Судалгаанаас үзэхэд,

- Хөрөнгө оруулалтаасаа хамгийн их ашгийг хүртэж байгаа маркетингийн мэргэжилтнүүдийн 52% нь интернетэд видео бичлэг байршуулдаг.
- Маркетингдаа видео бичлэг ашигладаг маркетеруудын үр ашиг видео бичлэг ашигладаггүй маркетеруудынхаас даруй 50%-иар илүү байна.
- Видео бичлэг үздэг хүмүүсийн 92% нь тухайн бичлэгийг гар утсаараа үздэг бөгөөд түүний 42% нь YouTube сүлжээнээс үздэг байна.

Видео бичлэгийн эхний 10 секунд нь хүмүүсийн анхаарлыг татаж чадвал тухайн бичлэг дуусах хүртэл хүмүүсийн анхааралд байдаг. Бичлэгт хамгийн тохиромжтой хугацаа 2 минут. Хэрвээ 2 минутаас илүү бичлэг хийх шаардлагатай бол дараагийн хамгийн тохиромжтой хугацаа нь 6-12 минут. Бичлэгийн хугацаа богино байх тусам хүмүүсийн анхаарлыг татдаг.

Аялал жуулчлалтай холбоотой мэдээллийн контентуудын 70% нь Фэйсбүүк-ээр шэйрлэгдсэн байдаг. Фэйсбүүк нь дан ганц “лайк” авах зориулалттай зүйл биш бөгөөд өөр бусад онлайн сурталчилгаануудтай адил олон боломжуудыг бий болгодог.



5.3 ЖУУЛЧНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ



Жуулчны мэдээллийн төв (ЖМТ) нь жуулчид гийчдийг угтдаг тухайн газрын зочлох үйлчилгээний “нэрийн хуудас” юм. Ашгийн бус байгууллага бөгөөд аялагчдыг үнэ төлбөргүй мэдээллээр хангадаг. Үйл ажиллагааны зарим чиглэлийг орлогын эх үүсвэр бүрдүүлэхэд зориулдаг. ЖМТ нь орон нутаг, ард иргэдийн өнгө төрхийг тодорхойлсон анхны босго бөгөөд үйлчилгээ нь мэргэжлийн өндөр түвшинд байх шаардлагатай. Дэлхийн аль ч оронд, ямар ч хотод гүн хөх өнгийн бичмэл “ай – i” үсгэн хаягтай байдаг ба жуулчид шүүд ЖМТ гэж ойлгодог. ЖМТ-ийг санхүүжүүлэгч нь орон нутгийн төр захиргааны байгууллага, түр компани, зочлох үйлчилгээний компан, соёл, урлагийн байгууллагууд, тээврийн компани, билетийн касс зэрэг байгууллагууд байдаг.

Мэдээллийн сан: Брошур, газрын зураг, зурагт самбар, дүрс бичлэг хэлбэрээр байх ба тухайн орон нутгийн зочид буудал, жуулчны бааз, эмнэлэг, цагдаа, зоогийн газар, баар, музей, үзвэрийн газар, билетийн касс, бие засах газар, орчуулгын товчоо, соёл урлаг, төрөл бүрийн арга хэмжээний хөтөлбөр, аяллын хөтөлбөр, хөтөч тайлбарлагч, жолооч, тогооч, байгаль хамгаалагч нарын мэдээлэл, жуулчин хонох боломжтой НИТАЖ-ын сүлжээнд хамрагдсан айл, аяллын машин түрээс, машин засварын газар гэх мэт үйлчилгээний бүхий л газрын мэдээллээс бүрдүүлнэ.

Худалдаа үйлчилгээ: Гарын авлага ном, сэтгүүл, ил захидал, хуанли, аймгийн тухай бичлэг, жижиг хэмжээний бэлэг дурсгалын зүйлс, газрын зураг, утасны нэгж зэргийг худалдах, хэвлэх ба хувилах зэргийг төлбөртэйгөөр зохион байгуулах.

Жуулчны мэдээллийн төвд зайлшгүй шаардлагатай техник хэрэгсэл

Техник хэрэгсэл	
1	Иж бүрэн компьютер, интернет шугам
2	Оффис ширээ, сандал, түлхүүртэй шүүгээ, бичгийн шургуулга
3	Жуулчинд мэдээлэл өгөх зориулалтын ширээ, сандал
4	Утасны аппарат, ажлын зориулалттай гар утас
5	Принтер (аль болох өнгөт), бичгийн цаас
6	Бүртгэл тооцооны дэвтэр, тооцооны хуудас, карт уншигч
7	Шаардлагатай бичгийн хэрэгсэл
8	Ус цэвэршүүлэгч, нэг удаагийн цаасан аяганууд



5.4 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ҮЗЭСГЭЛЭН

Дэлхийн хамгийн анхны үзэсгэлэн 1851.05.01-нд Лондон хотноо “Бүх нийтийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүний их яармаг” нэртэйгээр нээгдэж ихээхэн ашиг орлого олсон гэдэг. Англиас Германд үзэсгэлэнгийн маркетинг нэвтэрч 1928 онд “яармаг зохион байгуулахтай холбоотой конвенц”-ийг баталж, Олон улсын үзэсгэлэнгийн хороо (BIE буюу Bureau International des Expositions) байгуулагдсан. 1960-аад оноос “EXPO” гэж өөрчлөгдсөн бөгөөд олон улсын чанартай үзэсгэлэнгүүд ихэвчлэн 3-6 сард зохион байгуулагддаг болсон. 1980-аад оноос үзэсгэлэнгийн танхимд тухайн улс орны соёл, ёс заншилтай холбоотой зүйлсийг байрлуулах чиг хандлага үүсэж оролцогсдын 73% нь танхимаа бяцхан “ээзт гүрэн” мэт тохижуулж үндэсний брендийг сурталчлах үзэл дэлгэрсэн. Харин 2010 оноос эхлэн орчин үеийн ажил хэрэгч бизнес уулзалт, видео контент агуулга сурталчилгаа руу шилжсэн.

Монголын АЖ-ын ITM үзэсгэлэнд оролцоходоо дараах зүйлсийг анхаарах.

- Хэт их зардал гаргах тайз, талбай засалтаас татгалзах
- Үүрэг хариуцлага хүлээхгүй, дэмий цаг үрэх баг бүрэлдэхүүнээс татгалзах
- Ажил хэрэгч, чадамжтай багийн менежмент бүхий байдлаар оролцох
- Үзэсгэлэнд оролцох зорилго, ажил үүргийн хуваарийг тодорхойлсон байх
- Худалдан борлуулах зүйлсийн хувьд тусдаа менежмент хэрэгжүүлэх
- Танилцуулга, брошурьг худалдаалахгүй байх.
- Сүхбаатар гэж ялгарах таних тэмдэгтэй байх /үндэсний хувцастай байх албагүй/
- Унаган байгаль, нүүдэлчин малчин гэдэг улиг болсон сэдвээс татгалзах
- Борлуулахыг хүсэж буй аяллын маршрут дээр төвлөрөн ажиллах
- Үзэсгэлэнгийн үеэр уулзахыг хүссэн түр компаний захиралтай урьдчилан цаг тохирсон байх
- Үзэсгэлэнгийн талбайг маш цэвэрхэн оффис, ажил хэрэгч засалтаар засах
- Талбайд уулзалтууд, зочдод ундаа усны үйлчилгээ, видео танилцуулга явагдаж байх ёстой.
- Үзэсгэлэнгийн нийтийг хамарсан үйл ажиллагаа, хөтөлбөрт Сүхбаатар аймгийг танилцуулах илтгэл мэдээлэл, илтгэгчтэй байх хэрэгтэй.
- Сүхбаатар аймаг дахь зочид бүүдал, жуулчны бааз, эко гэр бүүдал, жуулчин хүлээн авах боломжтой малчин өрхийн танилцуулгуудыг сайтар бэлдсэн байх
- Цаашид үзэсгэлэнд оролцох зохион байгуулалтыг маркетингийн мэргэжлийн багт даатгах.



5.5 ЗОЧИД БУУДЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ

Мэргэжилтнүүд 2019 оны шилдэг зочид буудлын жагсаалтад Мальдив, Бали, Фижи, Занзибар, Мексик, Камбожи, Шанхайн зочид буудлуудыг нэрлэсэн. Шилдэг зочид буудлын шалгаруулалтанд хамгийн чухал үзүүлэлт нь үйлчилгээний стандарт, чанар байдаг бөгөөд буудал бүрт “зохион байгуулалтын схем” чухал үүрэгтэй.

Зочид буудлын зохион байгуулалтын схем гэж юу вэ.

Схем нь зочид буудлын ажлын явц, эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлсээ хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлын байрыг төлөөлдөг. Жижиг, дунд, том гэлтгүй зочид буудал бүрт зохион байгуулалтын бүтэц шаардлагатай байдаг.

Схемийг хүний нөөцийн захирал хариуцдаг. Ажлын байрны тодорхойлолтыг сайтар тодорхойлж, шинэ ажилчдыг ажилд авах, ажилтан бүр юу хийхээ мэдэхэд зайлшгүй шаардлагатай. Хүний нөөцийн чиг үүргийг аутсорсингоор гүйцэтгэсэн буудлууд олон бий.

Ерөнхий менежер/захирал: Хамгийн хариуцлагатай албан тушаал бөгөөд захиргаа, хяналт, бүтээн байгуулалтыг хариуцаж, бусад бүх хэлтсийн газруудын ажиллагааг баталгаажуулдаг. Мөн компанийн хэрэгжүүлэх бодлого, зорилтыг тодорхойлно.

Туслах менежер: Ерөнхий менежертэй зөвлөлдөхгүйгээр чухал шийдвэр гаргах эрхгүй боловч зочид буудлын хэвийн үйл ажиллагаанд гарч болох байнгын болон нийтлэг асуудлуудад шийдвэр гаргах үүрэгтэй.

- Шаардлагатай бүх мэдлэгийг эзэмшсэн байх
- Хууль эрхзүйн боловсролтой байх
- Хүний нөөцийн чиг үүрэг, даалгаврыг солих үүрэгтэй.
- Асуудал тулгарахад Б төлөвлөгөөтэй байх үүрэгтэй.
- Хурал, цуглаан, шуурхай зөвлөгөөнийг төлөвлөх, хянах



Захиргаа ба санхүү: Ерөнхий захиралтай асуудлыг хамтран хуваарилах, хянах үүрэгтэй.

- Санхүүгийн эх үүсвэр, төсөв зардал, хөрөнгө оруулалтыг компаний захирлууд, нэгжүүдтэй хамтран удирдах

- Хүний нөөцийн захиргаатай холбоотой үйл явцыг хянах
- Материаллаг нөөц хөрөнгө, үйлчилгээний хангамж, худалдан авалтыг хадгалах
- Санхүү, нягтлан бодох бүртгэлийн ажиллагаанд шинжилгээ хийх, хяналт тавих
- Жилийн төсөв, орлогын урьдчилсан тооцоо, санхүүгийн тайланг гаргах, хянах
 - **Захиргааны туслах ажилтан:** Захидал харилцааг боловсруулах, баримт бичиг хүлээн авах, дуудлагад хариулах, баримт бичиг бүрдүүлэх, файл боловсруулах, хэлэлцэх асуудлын жагсаалтыг бэлтгэх, танилцуулах үүрэгтэй.

Хүний нөөцийн дарга: Ерөнхий захирал, бусад менежерүүдтэй холбогдон ажилладаг.

- Ажилтнуудын ажиллах орчныг хангах, нөхцөлийг сайжруулах
- Ажилтнууд хоорондын зөрчлийг арилгах, зохицуулах
- Удирдлага болон ажилтан ажиллагсад хоорондын харилцааг хангах

Борлуулалтын менежер: Борлуулалт, сурталчилгааг бүрэн хариуцах үүрэгтэй.

- Үйлчлүүлэгчийг хайж олох
- Сайн үйлчилгээг санал болгох
- Үйлчлүүлэгчидтэй хийх гэрээг боловсруулах, хаах
- Зар сурталчилгааны стратеги боловсруулах, үйлчилгээг сурталчлах
- Борлуулалтын үр дүнг санхүүгийн хэлтэст мэдээлэх

Худалдааны туслах: Журмын дагуу нэхэмжлэх цуглуулахаас гадна дээд албан тушаалтан, борлуулалтын менежерийн ажлыг дэмжих, хийсэн борлуулалтыг хянах, ангилах, захиалах үүрэгтэй.

- Захиалгын хүсэлт, үзүүлэх үйлчилгээ, тэдгээрийн чек, төлбөрийг хянах
- Өрөөний хүртээмжийг тодорхойлох, захиалга авах, баталгаажуулах
- Дансны хөдөлгөөнийг мэддэг байх, асуудал гарвал түүнийг хариуцах

Үйлчилгээний менежер: Үйлчилгээний хэлтсийг хариуцдаг.

- Үйлчлүүлэгчдийн үйлчилгээний эргэлзээ, асуудлыг шийдвэрлэх
- Борлуулалтын зорилтыг биелүүлэх
- Ёсзүйн хэм хэмжээг дагаж, үлгэр дуурайлалтай ажиллах

Барааны менежер/агуулахын менежер: Шаардлагатай бүх бараа бүтээгдэхүүний хангамж, худалдан авалтыг хариуцдаг.

- Өөрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлд зориулж түүхий эд судлах, сонгох
- Байгууллагын менежментэд мэдээлэл, компьютерын системийг ашиглах
- Материал, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, багаж хэрэгслийн оролт гаралтыг хянах
- Хяналт, шалгалтыг үр дүнтэй болгохын тулд аудит, тооллого явуулах.



Хүлээн авах албаны менежер: Үйлчлүүлэгчтэй шууд холбогдож ажиллана.

- Ажилтнуудын ажлын цагийн хуваарийг гаргах
- Шаардлагатай тохиолдолд бусад хэлтэс, тасагтай холбогдох
- Хэрэглэгчийн үйлчилгээнд анхаарах, асуултанд хариулах, санал хүсэлтэнд хариулах, гомдлыг шийдвэрлэх

Өрөө үйлчилгээний менежер: Цэвэрлэгээ үйлчилгээ бол гол шалгуур байдаг.

- Үйлчилгээний хамгийн олон ажилтантай хэсгийг ахалж удирддаг.
- Буудлын бүхэл бүтэн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцах
- Сургалтанд хамрагдах, ажилтнуудыг найрсаг харилцаанд чиглүүлэх

Хоол, хүнсний менежер: Гал тогооны бүсэд хоол унд тус бүрд тогтоосон жор, стандартын дагуу хяналт тавих үүрэгтэй.

- Түүхий эд материалыг дэмий үрэхээс урьдчилан сэргийлэх
- Хоолны цэс бэлдэх, төлөвлөх
- Амттан, архи, дарс, үндсэн бараа материалын цар хүрээ, тоо хэмжээг хянах
- Шаардлагатай худалдан авалтыг хийх, хадгалалт хамгаалалтыг хянах

Рестораны менежер: Ресторан, зоогийн газрын бүх үйлчилгээ, зөв ажиллагааг зохицуулах, хянах үүрэгтэй.

- Үйлчлүүлэгчийг хүлээн авч, угтах, ширээ рүү газарчлах, суудал, байршил санал болгох
- Бүх ажилтнуудын ажил үйлчилгээ, цаг ашиглалтанд хяналт тавих
- Захиалга ба хангамжийг шалгах, шаардлагатай бол зөөгч нарт туслах
- Бараа материалын зохистой хэрэглээ, аяга тавагны гаралт, чанарт хяналт тавих

Ерөнхий үйлчилгээний менежер: Тоног төхөөрөмж, засвар үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажил хийх үүрэгтэй.


- Тухайн барилга, архитектурын бүтцийг мэддэг байх, удаан эдэлгээг хангах, шаардлагатай бүх арга хэмжээг авах
- Тоног төхөөрөмж, эд хөрөнгийн бүртгэл хийх, ажиллагааг шалгаж хянах
- Галын аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах
- Эрүүл ахуйн нөхцөл, шаардлагын байдлыг хангах, хянах
- Буудлын гадаах цэцэрлэг, түүний арчилгаатай холбоотой бүх зүйлийг хариуцах.

Засвар, үйлчилгээний инженер: Бүтээгдэхүүн, үйлчилгээ тасалдахгүй байх, хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй.

- Ажилтнуудаас засвар үйлчилгээний ажлын захиалгыг авах, зохицуулах үүрэгтэй.
- Засвар үйлчилгээнд шаардлагатай материалыг хүргэх, хүлээн авах
- Гүйцэтгэсэн ажлын захиалга, чанарыг баталгаажуулах
- Байгууламжид байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл ашиглалтын талаар сургалт явуулах

Хамгаалалтын албаны менежер: Болзошгүй эрсдэл, аюулаас сэргийлэх үүрэгтэй.





- Аюулгүй байдлын төлөвлөгөө гаргах, эрсдэлийн дүн шинжилгээ хийх
- Хяналтын систем, камерын үйл ажиллагааг хангах, хянах
- Үйлчлүүлэгч, ажилтан ажилчдын аюулгүй байдлыг хангах
- Машины зогсоолын талбайн хяналтыг хангах



ЖИШЭЭ: IBIS styles БИЗНЕС ЗОЧИД БУУДАЛ

Албан бизнес, ажил хэргийн аяллын жуулчдыг байршуулах зочид бүүдлын жишээ болгож Улаанбаатар хот дахь IBIS олон улсын сүлжээ зочид бүүдлыг товч танилцуулъя. Хан-Уул дүүрэгт Мишээл экспо төв рүү эргэдэг үзүүрт байдаг бөгөөд энэ нь Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудлаас УБ хотын төв рүү явах гол замын дагуу юм.

- Япон, Солонгосын бизнес зочид бүүдлуудын стандартаар барьж багуулсан бөгөөд барилгын гадаад үзэмж нүсэр бус, гоё ганган хээнцэр биш, чанартай барилгын материал ашигласан, энгийн цэвэрхэн архитектур дизайны шийдэлтэй.
- Бүх өрөө адил тэгш стандарттай бөгөөд албан бизнес, ажил хэргийн зорилгоор ирсэн зочид, жуулчдад зориулагдсан цэвэр цэмцгэр, ажил хийх орчныг хангасан тохижилттой.
- Хүний харааны түвшинд хаягжилт хийсэн, бичиглэлийн хувьд ойлгомжтой, үсгийн шрифт томоор хийгдсэн.
- Хөгжлийн бэрхшээлтэй, тэргэнцэртэй жуулчинд тухтай байж болохоор ариун цэврийн өрөөнүүдийг тохижуулсан.
- Босоо шүршүүрээс гадна усанд ордог онгоцтой. Зарим жуулчид усны онгоц ашиглах сонирхолтой байдгийг анзаарсан.



5.6 РЕСТОРАНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН СХЕМ

Рестораны зохион байгуулалтын схем нь хэн юу хийж байгааг ажиглахад зориулагдсан ашигтай арга зам юм.

Рестораныг үүсгэн байгуулагч: Тухайн байгууллагыг удирдан зохион байгуулж, хяналт тавина. Үйл ажиллагаанд хамаарах бүхий л лиценз, зөвшөөрлийг бүрдүүлэх, даатгалд хамрагдах, рестораны ерөнхий тохижилт, зохион байгуулалтыг хариуцаж, ажиллах дүрмийг тогтоодог.

Ерөнхий менежер: Рестораны гүйцэтгэл, санхүүгийн төлөвлөлт, үзүүлэх үйлчилгээ гэх мэт олон ажлыг хариуцдаг. Ерөнхий менежерийн шууд удирдлаганд туслах менежер, ерөнхий тогооч хоёр ажиллана.

Туслах менежер: Менежерийн албан тушаалд олон тооны ажил үүрэг хамаарахаас гадна долоо хоногт 60-аас дээш цагаар ажиллах шаардлага гардаг. Үйлчлүүлэгчид, ханган нийлүүлэгчдэд менежер нь бизнесийн нүүр царай болдог. Хоолны чанар, үйлчилгээний соёлтой холбоотой санал хүсэлт, гомдол ихэвчлэн менежер рүү чиглэдэг. Хангамжийн бараа материалыг бүртгэж, захиалгын тооцоог хариуцаж, ажилчдын ажлын цагийн хуваарийг гаргаж хянах үүрэгтэй.

Үйлчилгээний менежер: Рестораны байранд өрнөж буй бүх үйл явдлыг хянах, чиглүүлэх үүрэгтэй. Зөөгч, бармен, бартендер зэрэг ажилтнууд, эзэн, ерөнхий менежер хоорондын харилцааг хангаж ажилладаг. Зөөгч: Ширээний засалтын стандартыг хариуцна. Үйлчлүүлэгчдэд хоол ба уух юмны сонголт хийхэд нь тусална.

Гал тогооны менежер: Хоолы өрөөний хэсгийг хянах, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ, аюулгүй байдал, зохион байгуулалт, ажилтнуудад зориулсан сургалтыг хариуцдаг. Хоол үйлдвэрлэлд оролцож буй бүх ажилчдыг хариуцан ажилладаг. Ажлын орчин нөхцөлийг хангах, шинэ хоолны цэс ба хийх жорыг танилцуулах, хүнсний хангамж захиалах үүрэгтэй.

- **Ерөнхий тогооч:** Хоол бэлтгэх үйл ажиллагааг бүхэлд нь удирддаг.
- **Гүйцэтгэх тогооч:** Гал тогооноос гарч буй бүх хоолыг эцсийн байдлаар хянаж үйлчилгээний танхим руу гаргах үүрэгтэй. Хоолны цэсийг өөрчлөх, шинэ хоол хийх, бараа материалын жагсаалт гаргах, захиалга хийх үүрэгтэй.

Дарсны менежер: Баарны үйл ажиллагааг бүхэлд нь хариуцдаг. Бармен ба гал тогооны хэсгийг холбох, шингэн бараа материалыг хянах, тоолох, худалдан авах ажлыг хариуцдаг. Барааны судалгаа хийх, захиалга хийх, худалдан авах үйл явцыг хариуцна. Үйлчлүүлэгчдийг татах, баарны ажилтнуудыг удирдах үүрэгтэй.

Рестораны хүний нөөцийн төлөвлөлтөнд мөрддөг загвар: /100 суудалтай/

Тогооч	Зохион байгуулагч	Бармен (ээлжээр)	Зөөгч
Ерөнхий тогооч - 1			4
Туслах тогооч - 2	100 хүнд 1	100 хүнд 2	20-25 хүнд 1 буюу
Бэлтгэл тогооч - 2			4 ширээнд 1 зөөгч



5.7 НУТГИЙН БРЭНД БҮТЭЭГДЭХҮҮН ХӨГЖҮҮЛЭЛТ

Орон нутагт аялал жуулчлал хөгжүүлэх зорилгод нэг чухал үйлдвэрлэл бол нутгийн брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлох, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэх, хөрөнгө оруулалт татах, ажлын байр ба хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх гэх мэт олон зорилт төлөвлөлтүүд хүлээгдэж байдаг.

Сүхбаатар аймгийн “Дарьганга хүнс” төсөл амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд үхэр, хонины махыг УБ хотын хэрэглэгчдэд зориулан шинээр нь төхөөрч, монгол аргаар эвдэж, дотор өөх булчирхайг нь авч савлаад захиалгаар нийлүүлдэг. Сүхбаатар аймгийн махны амт чанар ялгарах онцлогтой хэмээдэг. Хэрэглэгчдэд шууд нийлүүлдэг учраас дундаа дамжлагагүй хүрдэг байна. Энэ төслийг дэмжин дэлгэрүүлж, аялагч жуулчдад таниулах нь хэрэгтэй.

Ариун цэврийн шаардлага хангасан өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, шинэ технологи нэвтрүүлэх, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, сав баглаа боодлын шинэчлэл хийх шаардлага бий.



ЗӨВЛӨМЖ:

- Сүхбаатарын мах, махан бүтээгдэхүүнийг БРЭНД болгон хөгжүүлэх, сав баглаа боодлын бодлого явуулах
- Жуулчдын урсгал нь хоол үйлдвэрлэлийг хөгжүүлдэг. Тийм учраас нарийн ногооны тариалалтыг хөгжүүлж жуулчны бааз, зочид буудал руу шууд нийлүүлдэг болгох
- Гахайн аж ахуй, бөднө шувууны аж ахуй, саалийн үнээний ферм, тахианы аж ахуй, галуу, цацагт хяруулын аж ахуй, жимс, жимсгэний аж ахуй, зөгийн аж ахуй, мод үржүүлгийн газар, эсгий үйлдвэрлэл, оёмол бүтээгдэхүүний гар урлал, мужаан үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх.
- Баруун-Урт хотын МСҮТ-ийн оюутан, залуучуудын үйлдвэрлэлийн технологи, дадлагыг бодлогоор дэмжиж, Сүхбаатар аймгийн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гол цэг болгох.
- Мужааны үйлдвэрлэл, модон гар урлалыг дэмжиж аймгийн аялал жуулчлалын бүс, жуулчны баазын нэр хаягийн самбар, замын тэмдэг тэмдэглэгээ, түүхэн болон дурсгалт газруудад босгох мэдээллийн самбарууд, хашаа хайс, сандал ширээ зэргийг зураг төслийн шалгаруулалтын дор давуу эрх олгон нутгийн гар үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж орлогожуулах.



5.8 АВТО ЗАМ ДАГУУХ ТҮР ЗОГСООЛ

Авто зам дагуух түр зогсоол нь аялал жуулчлалын хөгжилд маш чухал газруудын нэг юм. Сүхбаатар аймаг, Баруун-Урт хот руу чиглэсэн зорчигч, аялагчдын үрсгалыг ашиглаж орчин үеийн барилга байшин бүхий “Үйлчилгээний цэг” байгуулах боломжтой. Хоолны соёл, угтах үдэх үйлчилгээний соёлын шилдэг газар байх менежмент хэрэгжүүлж болно. Сүхбаатар нутгийн брэнд хоол үнд, жүнзтай шөл, борцтой шөл, хуймаг, сүүний хоол, үзэмчин цай, дарьганга цай гэх мэтээр өөрийн угсаатны хоол цайтай “түргэн хоолны үйлчилгээ”-тэй байх нь чухал.

Хоол үйлчилгээний танхимаас гадна оройн цагаар ажиллах уушийн газар, хүнсний өөртөө үйлчилдэг дэлгүүр, эмийн сан, цагдаагийн хэсэг, номын худалдаа, бэлэг дурсгалын дэлгүүр, аяллын мэдээллийн төв, бие засах газар байлгахгаар төлөвлөж бүтээн байгуулах нь зөв болно. Мөн явуулын гадаад, дотоод жуулчид хоноглож болох машин, мотоциклийн граж бүхий “мотель” байгуулбал олон улсын жишигт нийцсэн зам дагуух үйлчилгээний бүтээн байгуулалт болж чадна.



Жуулчны мэдээллийн төв нь Сүхбаатар аймгийн аяллын маршрутуудыг танилцуулах цэг байх юм. Үндсэн маршрутын самбарыг байрлуулж, хоггүй цэвэрхэн аялах, нутгийн ёс заншлыг хүндэтгэх, хил гаалиар гарахад анхаарах зүйл, мөрдөх журам зэргийн мэдээллийг байршуулах хэрэгтэй.



ЗӨВЛӨМЖ:

- Сумын ИТХ, ЗДТГ-аас Сүхбаатар аймгийн “угтах үүд” болгон хөгжүүлэх бодлого, хөтөлбөр баримтлах
- Хөрөнгө оруулалтын нээлттэй бодлого зарлаж гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад таатай нөхцөл санал болгох
- Франчайзингаар, орон нутагт ээлтэй гэрээгээр бизнесийн байгууллагад даатгаж байгуулах нь зөв шийдэл болно.
- Авто зогсоолыг цементэлсэн том талбайгаар тохижуулах, тэмдэг, хаалт, хашлага, орчны гэрэлтүүлэгтэй хийх
- Урт сандлууд байршуулах, мод суулгах, цэцгийн мандал хийх, хогийг ангилан хаях савнууд байршуулах
- Орчин үеийн бие засах газартай, эрэгтэй, эмэгтэй 3-4 байхаар, хүүхэдтэй хүнд зориулсан өрөө гэх мэтээр тохижуулах

5.9 ЭКО БИЕ ЗАСАХ ГАЗАР БУЮУ ХУУРАЙ ЖОРЛОН БАЙГУУЛАХ СТАНДАРТ

Эко 00, био 00 гэж юу вэ. **Эко 00** буюу хуурай жорлон гэдэг нь хүний ялгадас нүхэндээ хатаж эгшиж, хөрсөндөө шингэж, алсдаа бордоо болох, дүүрэхгүй олон жил болдог, олон жилийн дараа дүүрсэн ч шороогоор хучиж булаад 2-3 жилийн дараа хүний биед хортой бактериуд нь үхсэний дараа бордоо болгон ашиглах, эсвэл шууд дээр нь мод ч тарьж болох нүхэн жорлонг хэлж байгаа юм. Энэ нь хөрсний ус ойрхон биш газарт, ялангуяа говийн нөхцөлд хамгийн тохиромжтой жорлон юм. **Био 00** гэдэг нь тусгай зориулалтын саванд бие засаад зориулалтын химийн бодис хийж, хүний өтгөнийг задалж үнэрийг багасгаад тодорхой хэмжээнд хүрмэгц задарсан шингэнээ байгальд хаядаг, тээвэрлэж авч явахад хялбар, авсаархан зөөврийн жорлон юм. Эко 00 буюу хуурай жорлон нь Монгол орон даяар өрнөсөн “Жорлонгоо өөрчилье” хөтөлбөрийн хүрээнд туршсан хамгийн сайн хувилбар болсон юм.

АНХААРАХ ЗҮЙЛ:

- Эко 00 буюу хуурай жорлонд үртэс, сайр, элсэн давхарга, химийн элдэв задлагч, үнэр дарагч бодис зэргийг ерөөсөө хэрэглэхгүй. Бохир нь хөрсөнд 1-1.5 метрээс цааш нэвчдэггүй болох нь нотлогдсон. Хүний өтгөн, шингэн бохироос илүү химийн элдэв бодис нь байгальд хортой, бохирдуулагч, хордуулагч болдогийг санах хэрэгтэй.
- Жорлонгийн нүхийг нэг суултуурт 1x1м хэмжээтэйгээр 3м хүртэл гүн ухахад хангалттай. Жорлонгийн нүхийг аль болох нарийхан, гүн үхвал хүний өтгөн их талбайд тарж, тэр хирээрээ их үнэр ялгарахаас сэргийлнэ. Хөрсний нуралттай, эсвэл элс, сайр, дайрган хөрстэй биш бол жорлонгийн нүхийг заавал доторлох шаардлагагүй.
- Бохирыг нь соруулах зориулалттай хийж байгаа бол бетоноор доторлож болно. Гэвч соруулахын тулд ус хийж шингэлэн соруулах шаардлагатай болдог. Энэ нь эргээд исэлдэж ууршин хурц үнэрийг дээш гаргах болно. Хөрсний ус ойрхон газарт бат бөх бетон доторлогоо хийхээс өөр аргагүй. Харин түүний агааржуулалтын янданг сайн, зөв хийх хэрэгтэй болно.
- Жорлонд ялангуяа борооны ус оруулахгүй, элдэв хог хаягдал, бохир ус хийхгүй байх нь чухал. Өнөөг хүртэл монголчууд жорлон хийхдээ гаргаж ирсэн том алдаа бол Жорлон болон муу усны цооногоо нэг нүхэнд хийдэг явдал юм. Ус ба ялгадас холилдож бохир усан сан үүсгэснээс өтгөн задарч хатахгүй, орчиндоо маш хортой муухай үнэрийг тарааж, ялаа цуглаж үржих, гэдэсний болон бусад халдварт өвчин үүсгэх орчинг бий болгодог. Ялангуяа дулааны улиралд ийм жорлонд тэвчиж сүүхын аргагүй, хувцсанд хүртэл үнэр нь шингэдэг. Өөрөөр хэлбэл, хүчтэй ялзрал явагдаж хортой хий ялгарч байна гэсэн үг юм.
- Жорлонгийн дотор талыг хулдаасалбал цэвэрхэн орчин үүсэхээс гадна угааж цэвэрлэх, ариутгахад хялбар болно.



Эко 00 буюу хуурай жорлонгийн битүүмж сайн байх ёстой. Жорлон аль болохоор битүүмж сайтай байх хэрэгтэй бөгөөд гаднаас ялаа, мөн агаар орох зай завсаргүй байх тусам сайн. Хаалга үүд нь зай завсаргүй яв цав таарсан, агааржуулагч яндан нь жорлонгийн доторхи агаарыг сайн сорон гаргаж байх нь чухал. Жорлон бараан өнгөтэй байх тусам нарны гэрлийг өөртөө шингээн авч жорлон дотор дулаан болдог. Жорлонгийн дотор агаар дулаан байснаар агааржуулах яндангаар татагдсан дулаан агаар жорлонгийн нүхэнд дулааныг хүргэж өтгөнийг хурдан хатахад дэм болдог.


Суултуур хийх хэрэгтэй. Ихэнх жуулчид суултуур дээр сууж бие засдаг дадал зуршилтай. Мөн манай өндөр настан хүмүүс явган сууж бие засч чаддаггүйг анхаарах хэрэгтэй. Суултуур нь жорлонгийн нүхээр ил задгай харагдах ялгадсыг хааж далдлан бохир үнэрийг багасгахаас гадна тухтай сууж бие засах нөхцөлийг хангаж өгдөг. Суултуурыг зөв ашиглуулахын тулд жорлонд зориулалтын суултуурын цаасыг хангалттай тавьж өгвөл сайн.

Зарим тохиолдолд үнс, элс, модны үртэс зохих хэмжээгээр хийх хэрэг гарч магадгүй. Жорлонгийн нүхэнд шингэн буюу шээс их болж, шингэхгүй байгаа бол бүхэл багатай нунтаг үнс, ялангуяа аргал, хөрзөнгийн үнс бага зэргийг хийж өгвөл үнс шингэнийг өөртөө татаж, өтгөнийг хурдан хатаахад дэм болдог. Харин хажууд нь жижиг утгуур, тусгай саванд үнс, элс бэлтгээд тавьчихвал бүүр амар болно. Үртэс, элс, үнсийг хийхдээ их хэмжээгээр бус бага багаар хийх хэрэгтэй.

Агааржуулалтын янданг бүдүүн хийж хараар будна. Жорлонгийн агааржуулах яндангийн диаметр суултуурын нүхний диаметрээс болж өгвөл том, эсвэл түүнтэй ижил хэмжээтэй байх тусам суултуураас дээшээ үнэр гаргалгүй татаж чадна. Хэрэв агааржуулалтын янданг зөв диаметртэй, зөв байрлуулж, жорлонгийн дээврээс дээш 80см-ээс доошгүй өндөртэй хийсэн бол, бага зэрэг салхитай үед та суултуур дээрээ суугаад анзаарвал агааржуулалтын яндан, жорлон дахь агаарыг доош татаж байгаа нь илт мэдэгдэнэ. Энэ нь жорлон ба суултуурын доторхи агаарыг агааржуулах яндан доош сорж, бохир үнэрийг холдуулж байгаа гэсэн үг юм.

Жорлонгийн агааржуулах яндан гадаах дулааныг яндан дотор хурдан дамжуулах нимгэн материалаар хийгдэхээс гадна заавал хар өнгөөр будагдсан байх ёстой. Бохир усны 20см диаметртэй бүдүүн пластмассан хоолойг агааржуулах янданд ашиглаж болно. Агааржуулах янданг хар өнгөөр будсанаар нарны гэрэл хар өнгөн дээр илүү шингэж янданд дулаан үүсгэн доторхи агаарыг халааж, халсан агаар физикийн хуулиар өөдөө хөөрөхийн хирээр жорлонгоос үнэрийг хурдан татаж агаарт сарниулах болно. Яндан тагтай байх нь бороо, зурын ус жорлонгийн нүхэнд орохоос хамгаалдаг.

Агааржуулах яндан тавцантай суултуурын хөндийд, суултуурын аманд ойрхон, янданг 45 градусаар огтолж амсрыг суултуурын тийш чиглүүлсэн байх нь чухал. Ингэснээр агааржуулах яндан жорлонгийн доторхи цэвэр агаарыг суултуурын дээд нүхээр доош татаж дороос ирэх үнэрийг дээш гаргалгүй шууд гадаах орчинд гарган сарниулдаг.






Бие засах дүрэм. Суултуур дээр гишгэх, дээр нь гарч суухгүй байх ёстой. Хэрэв сэтгэлд сэжиг төрж эвгүй санагдаж байвал суултуурын зориулалтын цаасыг ашиглаад дараа нь хэрэглэсэн цаасаа заавал хогийн саванд хийнэ. Ашигласан ариун цэврийн цаас, ариун цэврийн хэрэглэлийг заавал хогийн саванд хаях ба суултуурын нүх рүү хэрхэвч хийж болохгүй.

Эрэгтэй хүн хөнгөнөөр бие засах бол суултуурыг сөхөөд бие засна. Ер нь эрэгтэй хүн ч гэсэн суултуур дээр сууж бие засах нь эр хүний хоёр дахь “зүрх” гэгдэх түрүү булчирхайн үрэвслээс хамгаалах, шээсийг бүрэн гадагшлуулахад хамгийн сайн гэдгийг санахад илүүдэхгүй. Хэрэв суултуур дээр суухгүйгээр босоогоороо хөнгөнөөр бие засах бол жорлонгийн нүх рүү бие засах ба орчныг бохирдуулахгүй байх нь хувийн асар том соёл болно.



Зураг 1: Жорлонгийн нүх хааш хаашаа 1м өргөн, гүн 3м ухагдсан байна. Хэрэв хөрсний ус доор бол 3м-ээс ч гүн ухаж болно. Хөрс нуранги биш бол доторлох шаардлагагүй. Нүх том биш байх тусмаа өтгөн шингэн бага талбайд тархаж ялгаруулах үнэр тэр хэмжээгээрээ бага гарах үндэслэлтэй. Агаарын яндан суултуурын нүхэнд аль болох ойрхон, доороос ирэх үнэрийг дээш гаргахгүйгээр сорохоор тооцож байрлуулах.

Зураг 2: Алдаатай хийгдсэн жорлон. Нүхийг хэтэрхий том үхсэн. Өтгөн шингэн их тарж үнэр ялгаруулах талбай том болсон. Агаарын хоолой суултуурын нүхнээс хол байрласнаас үнэрийг бүрэн татаж чаддаггүй. Нүхний арыг онгорхой, завсар ихтэй хийснээс битүүмжлэл алдагдаж агаарын хоолой жорлонгийн нүхнээс үнэрийг татахаасаа илүү гаднах агаарыг татдагийг сумаар дүрсэлсэн.

Зураг 3: Агаарын хоолойг суултуурт шууд холбож өгвөл үнэр дээшээ гарах магадлал бүр багасна. Агаарын хоолой суултуурын тагаар жорлонгийн доторхи агаарыг сорж доороос ирэх үнэрийг дээш гаргалгүйгээр сорж жорлонг үнэргүй, эсвэл маш бага үнэртэй болгоно.




Нийтийн жорлон: Америкийн Есомити (Yosemite) ТХГ-ын нийтийн жорлон. Жилд 3 сая жуулчид ирдэг энэ газарт машин хүрэх бололцоотой, хөрсний ус ойрхон учир жорлонгийн нүхийг бетоноор доторлож, бохирыг сорох зориулалттайгаар хийж, агааржуулах яндангийн дээр нарны гэрлээр ажилладаг цахилгаан сорох сэнс байрлуулсан. Зориулалтын хуванцар суултуур ашигласан. Жорлонгийн гадна талыг ус чийг үл нэвтрүүлэх зориулалтын будгаар будаж өнгөлсөн, сайтар хатаасан модоор хийж, дотрыг зориулалтын хуванцар материалаар доторлож, шалыг бетондож мөн зориулалтын будгаар будсан байв. Дотор ханыг дагуулан хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүс түшиж, барих бариулыг хийсэн байна.




ЗУРГАА. СҮХБААТАР АЙМГИЙН АЯЛЛЫН ҮНДСЭН МАРШРУТ


Маршрут 1: УБ – Баруун-Урт – Алтан-Овоо – Шилийн богд – Баруун-Урт – УБ (1546км)



МАРШРУТ 2: УБ – Хамарын хийд – Хужирт – Онгон таван булаг – Дарьганга – УБ (1710км)



МАРШРУТ 3: УБ – Түвшинширээ – Баяндэлгэр – Дарьганга – Баруун-Урт – УБ (1608км)



МАРШРУТ 4: УБ-Баяндэлгэр-Онгон-Дарьганга-Эрдэнэцагаан-Сүхбаатар-Баруун-Урт (2000км)




АЯЛЛЫН ХОНОГ: 8-9 ӨДӨР

- ★ Сумын төв
- Очих газрууд
- 20 Замын урт /км/
- Аяллын чиглэл


ЗОРИХ ГАЗРУУД:

1. Цагаан элэгний хадны зураг
2. Донгойн ширээ
3. Хужиртын хавцал
4. Онгон таван булаг
5. Шартын хад
6. Таван толгойн хүн хөрөг
7. Бударын чулуу
8. Шивээтийн хүн хөрөг
9. Жаахан шарга цогцолбор
10. Алтан-Овоо
11. Ганга нуур
12. Торой бандийн хөшөө
13. Шилийн богд
14. Талын агуй
15. Гөхөлийн хүн хөрөг
16. Бичигтийн шахаа, Хөрөгийн хөндий
17. Зотол хан уул
18. Мэндсайханы дов
19. Зүүн Нүхтийн хүн чулууд
20. Жаргалантын ширээний зураг, хүн хөрөг
21. Дугнагарын хүн хөрөг
22. Дархан хан уул
23. Нийгмийн хонгор цогцолбор

МАРШРУТ 5: Чойбалсан – Матад хан – Шилийн богд – Алтан овоо – Чойбалсан (986км)



МАРШРУТ 6: УБ – Хэнтий аймаг – Дорнод аймаг – Сүхбаатар аймаг – УБ (2840км)



ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Одоогийн хүчин чадал	Нэмэгдүүлэх боломж	Хөрөнгө оруулалт
1	Хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлэх, шалган нэвтрүүлэх цагийн хуваарийг нэмэгдүүлэх	Жилд нийт 1533000 машин тээвэр зорчигч	20-30%	Улс, аймгийн төсөв
2	Бичигтийн боомтын орчинд “Чөлөөт худалдааны бүс” байгуулах	зорчигч	10-20%	Улс, аймгийн төсөв
3	Боомт орчинд түр амралтын цэг, түргэн хоолны газар, “мотель” хэлбэрийн шинэ буудал байгуулах	Оюу буудалд жилд 3600 зочин	50-60%	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
4	Сүхбаатар аймгийн Аялал жуулчлалын холбоог байгуулах /Дарьганга, Эрдэнэцагаан, Баяндэлгэр, Онгон сумуудад салбар холбоо байж болно.	Байхгүй		Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
5	Жуулчны баазуудын нүхэн задгай жорлонгуудыг битүү хуурай, эко 00 болгох	2021 оны байдлаар 6 бааз	100% шинэчлэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
6	Зочин хүлээн авах үйлчилгээ, өглөөний цайны стандартыг засаж сайжруулах, үйлчлэгч, ажилтнуудын форм хувцаслалт, харилцааны соёлыг нэвтрүүлэх, ажлын байрны ёс журмыг мөрдүүлэх сургалтууд тогтмол явуулах	Жилд 1 сургалт	Жилд 2-3 сургалт	Аймаг, сумын төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
7	Зочид буудлыг Монголын одны зэрэглэлтэй болгож, зэрэглэл ахиулах	Одтой буудалгүй	4-5 хүртэл	
8	Зочид буудал, жуулчны баазуудын хүний нөөцийг нэмэгдүүлэх, чадамжийг дээшлүүлэх, тогтвортой байлгах, дотоод гадаадын тэмцээн уралдаанд ажилтнуудыг оролцуулдаг байх	16 буудал 361 ортой 50-60 ажилтантай	80-100 хүртэл нэмэгдүүлэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
9	Дарьганга, Түвшинширээ сумуудад АТМ нэмэгдүүлэх	АТМ байхгүй	Тус бүр 2-3 нэмэгдүүлэх	Банкны хөрөнгө оруулалт
10	Бэлэг дурсгалын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, сүлжээ дэлгүүрийг нэмэх, бүтээгдэхүүний чанар, сав баглаа боодлыг сайжруулах, урлаач, үйлдвэрлэгч нарыг дэмжих	1 дэлгүүр	5 хүртэл нэмэгдүүлж бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
11	Кофе, амттан, номын сан, номын худалдаа, интернет орчинг хослуулсан үйлчилгээг түлхүү хөгжүүлэх	2 кофе шоптой	5 хүртэл нэмэгдүүлэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт

12	Ресторан, хоол үйлчилгээний газруудын ариун цэврийн өрөөний стандартуудыг сайжруулах, нүхэн жорлонгуудыг хуурай эко 00 болгох	Аймгийн хэмжээнд 47 хоолны газартай	70% хүртэл	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
13	ХҮН ХӨРӨГ - ГАЛЕРЕЙ байгуулах төсөл	2020 онд 23000 жуулчин ирсэн	Жуулчдын 40-50% үзэх	Дотоод, гадаадын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
14	Ганга нуурын шувуу ажиглах төв – төсөл	2020 онд 23000 жуулчин ирсэн	Жуулчдын 20-30% саатах	Аймаг, сумын төсөв
15	Зэгст нуур – Эргийн аялал жуулчлалын төв	2020 онд 23000 жуулчин ирсэн	Жуулчдын 30-40% зорих	Дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
16	Адууны өв соёл музей – төсөл	2020 онд 23000 жуулчин ирсэн	Жуулчдын 20% үздэг байх	Дотоодын хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
17	Дарьганга урлалын төв – төсөл	2020 онд 23000 жуулчин ирсэн	Жуулчдын 20% үздэг байх	Аймаг, сумын төсөв
18	Нью Дарьганга – Олон улсын хүүхэд залуучуудын зуслан		Нэг ээлжинд 150-250 Жилд 4-5 удаа	Дотоодын хөрөнгө оруулалт
19	Агтана хүрээт – Өвлийн наадам Аялал жуулчлалын эвент болгон хөгжүүлэх	2020 онд 3000 хүн үзсэн	5000-6000 үзэгч болгож өсгөх	Аймаг, сумын төсөв
20	Зотол хан – Майхант отогийн бүс байгуулах	Жилд 1500 орчим жуулчин	4000 – 5000 хүртэл өсгөх	Аймаг, сумын төсөв
21	Зүүн бүсийн АЖ-ын хөрөнгө оруулагчдын чуулганд оролцох		20-30 хүний бүрэлдэхүүн	Төр, ТББ, хувийн хэвшил
22	ITM үзэсгэлэнд “гол түнш”-ээр оролцох		Талбайг нэмэгдүүлэх	Аймаг, сумын төсөв, ТББ, хувийн хэвшил

СҮХБААТАР АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ХЭТИЙН ЗОРИЛТ (2020 – 2028)

(Аялал жуулчлалын хөгжлийн асуудлыг тусгасан байдал)

Тэргүүлэх чиглэл 2: Эдийн засгийн тогтвортой хөгжил

Шинжлэх ухаан, технологи, инноваци, дэд бүтцэд тулгуурлан өрсөлдөх чадвар бүхий хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, аялал жуулчлалыг хослуулан хөгжүүлэх замаар бие даасан эдийн засгийн хөгжлийг хангана.

Зорилт 5.3 Унаган байгаль, түүх, соёл, нүүдэлчин ахуйг түшиглэсэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд суурилсан эко бизнес, хил орчмын аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлэх

5.3.1 Аймгийн аялал жуулчлалын салбарын судалгаа, шинжилгээ хийж зөвлөх үйлчилгээ авч, урт хугацааны хөгжлийн стратегийг боловсруулан хэрэгжүүлэх

5.3.2 Үйлчилгээний менежментийн зөвлөх үйлчилгээний байгууллагатай гэрээ байгуулах замаар аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх үйлчилгээний байгууллагын өнөөгийн түвшинг үнэлэх, мэргэжлийн зөвлөгөө авах, цаашид үе шаттай хөгжүүлэх дэд хөтөлбөр боловсруулах, хүний нөөцийг чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх

5.3.3 Баруун-Урт хотын аялал жуулчлалын имижийг бүрдүүлэх

5.3.4 Зан заншил, уламжлал, нүүдэлчин ахуйд түшиглэсэн аялал жуулчлалын имижийг бүрдүүлж эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, бүс, маршрутыг тодорхойлох, мэдээлэл, танилцуулгын гэрэлт самбаруудыг байршуулах, аялал жуулчлалын хог хаягдлын менежментийг шийдвэрлэх, нутгийн аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран хөгжүүлэх

5.3.5 Нутгийн иргэдийн байгаль орчин, аялал жуулчлал, үйлчилгээний менежментийн талаархи боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, нутгийн онцлогийг илэрхийлсэн гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх өрхийн үйлдвэрлэлийг дэмжих, урлаг, урлаг соёлын үйлчилгээ үзүүлэх өрхүүдийг тодорхойлж чадавхижуулах, малчдын ахуй амьдралтай танилцах орчин бүрдүүлэх замаар орон нутгийн хөгжил, ард иргэдэд орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх

5.3.6 Нутгийн өв соёлыг сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, маркетинг, сурталчилгааг хөгжүүлэх

5.3.7 Төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлж, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах замаар стандартын шаардлага хангасан жуулчны баазыг байгуулж, жуулчдын ая тухыг хангах орчныг бүрдүүлэх

5.3.8 Аялал жуулчлалын хөрөнгө оруулалтыг дэмжих, мэргэшсэн, чадварлаг баг, компаниудыг ирж ажиллах сонирхлыг татах бодлого баримтлах нутгийн иргэдийг сургаж ажиллуулах, зарим бараа, ажил үйлчилгээг хангах нийлүүлэх нөхцөлтэйгөөр аялал жуулчлалын зөвшөөрөл олгох



5.3.9 Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу зам харилцаа, холбоо, эрчим хүчний хангамжийг сайжруулах, авто зогсоол, үйлчилгээний төв, ариун цэврийн байгууламжийн олон улсын стандартад нийцүүлэн бий болгох

5.3.10 Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэн, гадаад жуулчны урсгалыг нэмэгдүүлэх

5.3.11 Хууль зөрчиж байгаль орчинд халтай аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулсан этгээдийн хүлээх хариуцлагыг чангатгах, дүрэм журмыг чанд сахиулах

6.1.4 Аялал жуулчлалын гол цэгүүдийг тодорхойлж тэдгээрийг уламжлалт болон сэргээгдэх эрчим хүчээр хангахад дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах

6.3.3 Аялал жуулчлалын гол цэгүүдийг тодорхойлж, автозамын сүлжээнд холбох ажлыг дэмжих, хамтран ажиллах

6.3.4 Баруун-Уртын нисэх буудал, орон нутгийн нислэгийг сэргээн хөгжүүлэхэд санаачилга гарган, хамтран ажиллах

6.3.5 Аймгийн нутаг дэвсгэр дээгүүр дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замуудад технологид суурилсан төлбөр хураах цэг, хяналтын пост барих болон үйлчилгээний цогцолбор барих, газрын асуудлыг шийдвэрлэх, хувийн хэвшлийн хөрөнгө оруулагчдад дэмжлэг үзүүлэх

6.3.9 Улсын чанартай автозам дагуу 150 – 200 км тутамд үйлчилгээний цогцолбор байгуулах хөгжүүлэх

6.3.10 Жижиг нисэх онгоц, нисдэг тэрэгний зах зээлийг хөгжүүлэх, гамшгаас хамгаалах, хүнс, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, уул уурхай, аялал жуулчлалын салбарт ашиглах

6.4.2 Мэдээлэл харилцаа холбооны салбарын статистик мэдээллийн сан бүрдүүлэх, аялал жуулчлалын бүс болон шаардлагатай бусад цэгүүдэд сүлжээний өргөтгөл хийх чиглэлээр хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч ажиллах, тэдний санал санаачилгыг дэмжих

8.1.1 Экологийн чухал ач холбогдол бүхий газруудыг улс болон орон нутгийн тусгай хамгаалалт, тусгай хэрэгцээнд авах, шинжлэх ухааны ач холбогдол бүхий тусгай цэгүүдийн тоог нэмэгдүүлэн хамгаалалтанд авах ажлыг эрчимжүүлэх

8.2.2 Ховор, нэн ховор амьтан ургамлыг зориудаар өсгөн үржүүлэх, сэргээн нутагшуулах, тарималжуулах, зохистой ашиглалтыг дэмжин ажиллах

8.2.4 Ан агнуурын менежмент төлөвлөгөөг хэрэгжүүлэх, ан амьтан, байгалийн ургамлын нөөцийн судалгаа хийж, биологийн төрөл зүйлийн нөөцийг нэмэгдүүлэх



СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020 – 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

(Аялал жуулчлалын хөгжлийн асуудлыг тусгасан байдал)

- 2.6.1.1 Үл хөдлөх дурсгалуудыг хамгаалах, хүн чулууны хадгалалт хамгаалалтыг сайжруулах
- 2.6.1.2 Соёлын биет бус өв тээгчдийн судалгааг бодитой болгон, өвлөн уламжлуулах арга хэмжээг зохион байгуулах
- 2.6.2.1 Угсаатны зүйн музейн стандартын шаардлага хангасан барилга барих
- 2.6.2.2 Орон нутгийн угсаатны зүйн музейн үзмэрийг хүүхэд бүрд үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах
- 2.6.3.1 “Өв соёл”-ын эвент арга хэмжээнүүд зохион байгуулах
- 2.6.3.2 “Дарьгангын соёлын өв”, “Сүхбаатар аймаг” брэнд, брэндбүүк бүтээх, соёл урлагийн болон сурталчилгааны контент шинээр бий болгож, олон нийтэд сурталчлах, сүвгийн хөгжүүлэлт хийх
- 3.3.15.2 Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгох, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, байгаль орчинд ээлтэй АЖ-ыг хөгжүүлэх

- 3.4.1 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг сайжруулна
 - 3.4.1.1 Аймгийн аялал жуулчлалын нөөц, даацын судалгааг хийх
 - 3.4.1.2 Аймгийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн дунд хугацааны стратегийг боловсруулан хэрэгжүүлэх
 - 3.4.1.3 Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ААНБ-д зөвлөх үйлчилгээний сургалт зохион байгуулж, стандартын түвшнийг нэмэгдүүлэх
 - 3.4.1.4 Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу стандартад нийцсэн түр буудаллах цэг байгуулах
 - 3.4.1.5 Аялал жуулчлалын бүс бүрд нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлж, нүүдлийн соёл иргэншлийг харуулсан морь, тэмээн аялал, шувуу ажиглах, язгуур урлаг, өв соёлын арга хэмжээ зохион байгуулах
 - 3.4.1.6 Хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх гадаад жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх
 - 3.4.1.7 Эрдэнэцагаан суман дахь 80 ортой зочид буудлыг бүрэн ашиглалтад оруулах, үйл ажиллагааг тогтмолжуулах
- 3.4.2 Аялал жуулчлалын маркетинг сурталчилгааг өргөжүүлнэ.
 - 3.4.2.1 Үйлчилгээний байгууллага, иргэдэд аялал жуулчлалын менежментийн талаар боловсрол олгох, тэдний бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжих, үзэсгэлэнд оролцуулах
 - 3.4.2.2 Аймгийн аялал жуулчлалыг сурталчилсан ном товхимол хэвлүүлж, бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах
 - 3.4.2.3 Аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг эрчимжүүлэх
 - 3.4.2.4 Орон нутгийн өв соёлыг сурталчлан таниулах эвент арга хэмжээг зохион байгуулж, тогтмолжуулах
- 3.4.3 Аялал жуулчлалын бүс нутаг дахь орчны бохирдлыг бууруулна.
 - 3.4.3.1 Аялал жуулчлалын бүс нутагт эко ариун цэврийн байгууламж /00/ байгуулах
- 5.1.1.1 Иргэдэд байгаль хамгаалах, ногоон хөгжлийн боловсрол олгох сургалт, арга хэмжээ зохион байгуулах
- 5.1.1.4 ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх



СҮХБААТАР АЙМГИЙН ЖУУЛЧНЫ БААЗЫН НӨӨЦ

№	Сумын нэр	Баазын нэр	Ажиллах хуваарь	Байшин ба гэрийн тоо	Орны тоо	Бие засах газрын нөхцөл	Холбогдох утас
1	Баруун-Урт сум	Наадаан	4 улирал	Байшин – 6 Гэр – 10	76	Боловсон 00-той	99634949 86896767 86886767
2	Баруун-Урт сум	Хүслийн хүслэн	4 улирал	Байшин – 4 Гэр – 8	40	Задгай 00-той	
3	Баруун-Урт сум	Шандын унага	4 улирал	Байшин – 2 Гэр – 3	16	Задгай 00-той	99113496
4	Дарьганга сум	Гангар хун	VI – IX сар	Байшин – 3 Гэр – 10	56	Задгай 00-той	99170299
5	Дарьганга сум	Шилийн богд	4 улирал	Байшин – 0 Гэр – 8	40	Задгай нүхэн 00-той	91033140 99690976
6	Дарьганга сум	Талын агуй	4 улирал	Байшин – 0 Гэр – 10	80	Задгай нүхэн 00-той	99261659 96061659
7	Эрдэнэцагаан сум	Энергит тал	VI – IX сар	Байшин – 0 Гэр – 10	40	Задгай нүхэн 00-той	96960818 88575759
					348		



СҮХБААТАР АЙМГИЙН ЗОЧИД БУУДЛЫН НӨӨЦ



№	Сумын нэр	Буудлын нэр	Өрөөний тоо	Орны тоо	Өрөөний үнэ	Бие засах газрын нөхцөл	Холбогдох утас
1	Баруун-Урт	Дарьганга	39	80	100000 – 220000₮	Өрөөндцөө 00-той	99173971 77413333
2	Баруун-Урт	Их уул	7	14	35000 – 50000₮	Өрөөндөө, нийтийн 00-той	99057905 99109323
3	Баруун-Урт	Нийтлэг үйлчилгээ	6	16	30000 – 60000₮	Дотроо нийтийн 00-той	86012375
4	Баруун-Урт	Сод	8	15	30000 – 45000₮	Өрөөндөө, нийтийн 00-той	99025352
5	Баруун-Урт	Соло	14	30	35000 – 60000₮	Өрөөндөө, нийтийн 00-той	99093981
6	Баруун-Урт	Тансаг	9	18	50000 – 95000₮	Өрөөндөө, нийтийн 00-той	99112001
7	Баруун-Урт	Ургах наран	9	19	40000 – 60000₮	Дотроо нийтийн 00-той	99070231
8	Баруун-Урт	Урт цагаан	8	16		Өрөөндөө 00-той	99770048
9	Баруун-Урт	Хүннү	15	28	40000 – 70000₮	Дотроо нийтийн 00-той	99515005 95006902
10	Баяндэлгэр	Рич	5	10	70000 – 90000₮	Өрөө бүр дотроо 00-той	95899862
11	Түмэнцогт	Тамир	7	16	30000 – 50000₮	Дотроо нийтийн 00-той	98987406
12	Эрдэнэцагаан	Баянбулаг	8	25	30000 – 50000₮	Дотроо нийтийн 00-той	85332333 70515333
13	Эрдэнэцагаан	Дэлгэрэх	7	20		Гадаа нүхэн 00-той	99703300
14	Эрдэнэцагаан	Оюу	8	15	40000 – 50000₮	Гадаа нүхэн 00-той	94480000
15	Эрдэнэцагаан	Уртын цагаан овоо	11	20	25000 – 40000₮	Дотроо нийтийн 00-той	99010565
16	Эрдэнэцагаан	Чандмань II	7	19	30000 – 40000₮	Дотроо нийтийн 00-той	99961991
			168	361			



ЗАХИАЛСАН, ХЯНАСАН:

Сүхбаатар аймгийн **БОАЖГ**



БОЛОВСРУУЛСАН:

Монголиан гайд түр ХХК
Аялал жуулчлалын судлаач, зөвлөх **Ч.Буянбадрах**



ГЭРЭЛ ЗУРГИЙН САН:

Чөлөөт уран бүтээлч **Д.Амараа**